**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН**
**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

**2023 оны 12 дугаар сарын 31** **Номгон**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | 1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 1. Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 100 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах чиглэлээр албадын бэлтгэл бэлэн байдлыг 100 хувь хангуулсан. | 100% |
| 2 | | 2. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлтгэл, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 8,066 сая төгрөгийг зарцуулсан. | 95 | Аймгийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль зохион байгуулах тухай” А/191 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 4 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд Жинст, 2023 оны 10 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Баянбулаг сумдад тус тус гамшгаас хамгаалах “Иж бүрэн” дадлага, сургууль, 2023 оны 4 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Шинэжинст, 2023 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Бөмбөгөр сумдад тус тус гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын дадлага, сургууль, Гурванбулаг, Баянцагаан сумдад “Бэлэн байдлын үзлэг”-ийг тус тус зохион байгуулсан. Иж бүрэн” сургуулийг Жинст сум 93,2 хувь, “А”, “Дүүрэн хангалттай”, Баянбулаг сум 84,5 хувь, “В”, “хангалттай”, “Команд штаб”-ын сургуулийг Шинэжинст сум 90,6 хувь “А” “Дүүрэн хангалттай”, Бөмбөгөр сум 87,5 хувь “В” “хангалттай” үнэлгээтэй, Гурванбулаг сум 85,2 хувь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “В” “хангалттай” үнэлгээтэйгээр зохион байгуулсан. Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн нийт 680 орчим ажилтан, албан хаагч, иргэд оролцож гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн. | |
| 3 | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлнэ. | 1. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх | 2021 - 2024 | | 95 | Эрүүл мэндийн сайдын А/48, А/85 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, 18 сумын эрүүл мэндийн төвүүдэд спирометр, түүний дагалдах хэрэгслийг хуваарилж хангалтыг хийсэн. Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Шуурхай удирдлагын нэгжийн тоног төхөөрөмжийг орлогод авч хуваарилах тухай” А/60 дугаар тушаалын хүрээнд 7 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, мэдээллийг түргэн шуурхай байдлыг хангахаар ашиглаж байна. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг тасралтгүй байдлыг хангах 2 удаагийн нээлттэй тендер зарлан татан авалт, хуваарилалтыг хийсэн. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 80 хувь, амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж 98 хувь, ковидын үед шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн хангалт 80 хувьтай байна. Эрүүл мэндийн анхан шатны нэгжүүд нөөцийн мэдээг ЭМЯ-ны нэгдсэн цахим системд тогтмол оруулж хэвшсэн. Ковид-19 халдвар болон, томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед шаардлагатай лабораторийн оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тестийн 3 сарын нөөцийг бэлтгэн, бэлэн байдлыг хангасан. | 100% |
| 4 | 1.1.3. Иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | 1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг | 2021 - 2024 | | 90 | SARS CoV2 вирусийн омикрон хувилбарын хвв 1.5 шинэ дэд хувилбар бүртгэгдсэнтэй холбоотой ХӨСҮТ-с ирүүлсэн зөвлөмжийн дагуу нэгдсэн эмнэлэгт хийгдэх ажлын төлөвлөгөөнд 2023 оны 05 сарын 08-нд тодотгол хийж 10 заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан, төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Аймгийн хэмжээнд Ковид-19 халдварын нийт 203 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 22.9 байгааг 2022 оны мөн үетэй (810.8) үетэй харьцуулахад 787.9 тохиолдлоор буурсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангах | | | | үзүүлэлттэй байна. -Тандалтаар нийт ойрын хавьтал болох 307 иргэнээс тухай бүр нь асуумж судалгаа авч, зөвлөмж, зөвлөгөөг өгч ажилласан. -Тусгаарлах эмнэлэгт хүнд болон хүндэвтэр нийт 73 тохиолдол эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүндрэл, нас баралт бүртгэгдээгүй. Коронавируст халдвараас сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг Эрүүл мэндийн газрын пэйж хуудас, эрүүл мэндийн анхан шатны 24 нэгжийн цахим хуудсаар 2 төрлийн видео шторк, 14 төрлийн зурагт хуудсыг байршуулж 102 удаа хуваалцаж, 8730 удаагийн хандалт авсан. Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээг Өдөр бүр Эрүүл мэндийн яаманд хүргүүлж байна. | |
| 5 | 1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. “Ковид-19” вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцох | 2021 - 2024 | | "Бага" | Ковид-19” вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг Шадар сайдын 28 дугаар тушаал дагуу ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Онцгой байдлын газар болон бусад байгууллагатай хамтран хийх боломжтой болсон. Аймгийн хэмжээнд Ковид-19 халдварын нийт 203 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 22.9 байгааг 2022 оны мөн үетэй (810.8) үетэй харьцуулахад 787.9 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.Одоогийн нөхцөл байдлаар ковидын халдварын тархалтын түвшин ”НОГООН” түвшинд байна. | 100% |
| 6 | | 2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх | 2021 - 2024 | | 90 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах зорилгоор “Төв штаб”-ын бүтцийг шуурхай бүлгийн бүтэц бүрэлдэхүүнд шилжүүлж, албадын бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Коронавируст халдвар (Ковид-19)-ын 2023 оны бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжилтийг хангаж ажилласан. Аймгийн онцгой комиссын 2 удаагийн хуралд оролцож Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, Томуу томуу төст өвчний тархалтын мэдээллийг мэргэжлийн ангийн албадуудад өгч мэдээлэл өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн хэмжээнд Ковид-19 халдварын нийт 203 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 22.9 байгааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 787.9 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар ковидын халдварын тархалтын түвшин ”НОГООН” түвшинд байна. Бэлэн байдлыг ханган ажиллах чиглэлд амьсгалын замын өвчлөлийн халдварын хүндрэл, эрсдэлээс сэргийлэх зорилгоор зорилтот бүлгийн 2-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчтэй 65-с дээш насны хүмүүс, эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд нийт 7720 хүнийг 100% хамруулсан, 10 сартайгаас 8 хүртэлх насны хүүхдүүдэд Улаанбурхан, улаануудын эсрэг вакциныг хийж, нийт 10031 хүн хамруулан халдвараас сэргийлэн ажиллаж байна. | |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | |
| 7 | 2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | 1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | 2021 - 2024 | Улсын төсвийн 208.0 сая төгрөг | 90 | Анхан шатны нэгжүүдээс 2021 онд тоног төхөөрөмжийн судалгаа авч, нэгтгэн дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангахаар ажилласан. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 6/23 дугаар тогтоолоор батлагдсан. Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд анхан шатны 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвийг гематологийн болон биохимийн бүрэн автомат анализатороор /цусны дэлгэрэнгүй, элэгний үйл ажиллагааны шинжилгээ/ хангаж тоног төхөөрөмжийн хангалт 85 хувьтай байна | 90% |
| 8 | | 2. Уламжлалт-сэргээн засах төвийг шинээр зохион байгуулан, шаардлагатай багаж хэрэгслээр ханган, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Гүйцэтгэлийн санхүүжилтээр | 3000 | Уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг Нэгдсэн эмнэлгийн тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Баян ундрага зэндмэнь, Амар амгалан Шаргалжуут сувилал, хувийн хэвшлийн ортой эмнэлэг Ганзүү, клиник (Дуут баян богд, Ганууд, Наран оч, Дэр сил) зэрэг аймгийн хэмжээнд нийт 32 эмнэлэг уламжлалт эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна. Уламжлал анагаах ухааны тусламж үйлчилгээг 3-16 нэр төрлөөр, сэргээн засах тусламж үйлчилгээг 3-11 нэр төрлөөр үзүүлсэн. Шинээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг эмчилгээ үйлчилгээнд ашиглан эмчилгээний нэр төрлийг олшруулан Ультразвук эмчилгээг давхардсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоогоор-340, цахилгаан гүйдэл эмчилгээ-УВЧ-3325, искра-950, цахилгаан бумба эмчилгээ-2265, лазер эмчилгээ-480, цахилгаан зүү-1652, хаш чулуун ор-458, татлага эмчилгээ-525, шавар эмчилгээ-1120, төөнө-350, улаан туяа-2630, хүнд самнуур-144 хийсэн байна. Шинээр хөдөлгөөн засалчийг орон тоогоор ажиллуулан, нийт давхардсан тоогоор 15495 хүнд уламжлалт эмчилгээ хийж, 968 хүнийг эрүүл мэндийн зөвлөгөө, дасгал хөдөлгөөнд хамруулсан. | |
| 9 | | 3. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж хэвшүүлэх | 2021 - 2024 | Гүйцэтгэлийн санхүүжилтээр | 16.1 | Зүрхний шигдээсийн палатыг энэ оны 11 дүгээр сараас эрчимтийн тасгийн хэсэгт зохион байгуулж, яаралтай тусламжийн бэлэн байдлын хүрээнд хананы хүчилтөрөгч, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, амьсгалын болон зүрхний бичлэгийн аппарат, монитори, дефибриллятор зэрэг тоног төхөөрөмж, яаралтай тусламжийн эм эмнэлгийн хэрэгслээр хангасан. Энэ хугацаанд 3 хүнийг оношилж, яаралтай тусламж үзүүлэн Өвөрхангай аймгийн БОЭТ-д хүргэсэн. Амбулаторит зүрх судасны 1 кабинет ажилласнаар: Үзлэг оношлогоо 4996 хүнд хийж, идэвхитэй хяналтад 27 хүн авч, хяналтаас хасагдсан 2, нийт 394 хүн хянагдаж байна. Зүрхний цахилгаан бичлэг -4708 хүнд, зүрхний эхо- 454 хүнд хийж, онош тодруулсан. Шинээр зүрх судасны 26 өвчлөл (тогтворгүй бах -1, зүрхний архаг дутагдал -8, зүрхний шигдээс -7, тосгуур ховдол хоорондын цоорхой-4, АДИӨ-3, ТЭЛА – 3) -ийг илрүүлсэн. Мөн шинээр анх удаа Миксом хавдар илрүүлэн 3-р шатлалд явуулж, онош тохирч хагалгаанд орсон. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг рүү онош тодруулахаар нийт 42 хүн илгээж, онош тодруулан эмчилгээ хийлгэж, хяналтад авсан. УГТЭ-ийн зүрхний хэм алдалтын эмч нар Нэгдсэн эмнэлэг, өрх сумын Эрүүл мэндийн төвийн эмч нарт зүрхний ЭХО, үений ЭХО, 24 цагийн зүрхний ЭКГ-г бичлэг хийх сургалтыг явуулж, нийт 12 эмчийг ажлын байрны чадавхжуулах сургалтад хамруулсан. Зүрх судасны төв, “МОН-007” төслөөс ЭХО-ны аппаратаар хангагдсан. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээ тодорхой түвшинд хийгдсэн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болович 2023 оны байдлаар өвчлөл 20,5 хувиар өсөж, зүрх судасны шалтгаант нас баралт нэмэгдсэн байна. | |
| 10 | | 4. Уушигны дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх | 2021 - 2024 | Улсын төсөв 139,0 сая төгрөг /эрүүл мэндийн яам / /байгууллагын төсөв 5 сая / | 3.9 | Нэгдсэн эмнэлэгт уушги судлалын нарийн мэргэжлээр 1 их эмч бэлтгэгдсэн, цаашид дурангийн чиглэлээр сургахаар саналаа Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Уушгины дурангийн багаж, тоног төхөөрөмжөөр хангагдаж орон нутагт өвчлөлийг илрүүлэх боломж бүрдсэн. Сүрьеэгийн өвчлөл 2023 онд 10 000 хүн амд 3.6 болж, өмнөх оноос 0.6 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100% |
| 11 | | 5. Вирус судлалын лабораторийг шинээр нээх | 2022 - 2024 | Байгууллагын төсөв 5 сая төгрөг | 15 | Вирус судлалын лабораторид 347 сорьцын шинжилгээ хийгдсэн. Үүнээс: SARS-19 болон томуугийн АВ хүрээний 86 вирус тодорхойлох шинжилгээнээс 42 (48,8%) эерэг бүртгэгдсэн. ХӨСҮТ-д илгээсэн шинжилгээнд 100 хувь тохироо таарч баталгаажуулалт хийгдсэн. Шинжилгээний гадаад хяналтыг 2 удаа (ХӨСҮТ болон олон улсын) хийлгэн “Хангалттай” үнэлгээ авч, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийх эрхээ авсан. Жилийн эцсийн байдлаар Молекул биологийн лаборатори нь 608 сорьцонд үүсгэгч илрүүлэх шинжилгээг хийж, бэлгийн замын PCR 33, амьсгалын замын PCR-н шинжилгээ 575 хийсэн байна. Нийт вирус судлалын лабораторийн нийт шинжилгээний 23 хувийг вируслогийн шинжилгээ эзэлж байна | 100% |
| 12 | | 6. Элэгний В вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | Байгууллагын төсөв | 150 | Аймгийн хэмжээнд 2023 онд шинээр хяналтад орсон нийт 1339 эхийг В вирусийн шинжилгээнд хамруулахад, В вирустэй 70 эх илэрсэн. Вирус илэрсэн эхчүүдийг бүрэн эмчилгээнд хамруулсан. В вирустэй 70 эхээс 65 тохиолдолд иммунглобулин G хийсэн. Цаашид В вирустай эхчүүдийн хяналтыг сайжруулан, иммуноглобулин G нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 13 | 2.1.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний | 1. Цэргийн насны 18-25 насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, | 2021 - 2024 | | 200 | 2023 оны 1-р ээлжийн цэрэг татлага 04 дүгээр сарын 19-28-ны өдрүүдэд Баянхонгор сумын 1,2,3,4,5,6,7,8,9,10-р баг, Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо, Баянхонгор сум зэрэг сумдад нийт 620 цэргийн насны | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх | | | залуучуудыг, 2-р ээлжийн цэрэг татлага 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд Баянхонгор сум, Баяновоо, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баянөндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут зэрэг 20 сумын 771, нийт 1391 цэргийн насны залуучуудыг үзлэг шинжилгээнд хамруулсан. Үзлэгт хамрагдсан залуучуудын 869 (62,4%) нь эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй байна. Илэрсэн өвчлөлийг назологиор нь авч үзвэл: Шүдний өвчлөл – 514, Дотрын өвчлөл – 238, Мэдрэл,сэтгэц - 280, Нүдний өвчлөл – 193, Чих хамар хоолойн өвчлөл – 204, Мэс засал, гэмтэл – 384, Арьс харшил- 290 илэрсэн. Цаашид бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилт 85 хувьтай ажиллаж байна. | |
| 14 | | 2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх | 2022 - 2024 | Байгууллагын төсөв | 400 | Мэс заслын 1 эмчийг урологи, андрологийн мэргэшүүлэх сургалтад хамруулж, иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетийг амбулаторит ажиллуулж, ЭМЯ-аас урологи-андрологийн мэс заслын тусламж үйлчилгээний 9 нэр төрлийн 151,438,093 төгрөгний багаж тоног төхөөрөмжийг “Пролианс” ХХК- аас нийлүүлсэн. Нийт 102 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлснээс, урологийн хагалгаа нийт 57 хүнд хийсэн байна. Үүнд: Давсагны чулуу авах -3, Түрүү булчирхай-28, Шээдэг сүвний нарийсал 1, давсагны чулуу авах-1, Шээдэг сүвний нарийсал, түрүү булчирхай-3, Түрүү булчирхай, давсагны хавдар авах-1, Шээлгүүрт стент гуурс тавих мэс засал -7, Бөөрөнд гуурс тавих-1 /Шинэ хагалгаа/ Бөөр авах-2, Давсагны хүзүү хэсгийн цус алдалт-1, Түрүү булчирхай, давсагны чулуу авах-1, Фимиоз-19, Төмсөг буулгах-3, Төмсөгний судасны бүдүүрэл-7 зэрэг хагалгааг иргэдэд эмчилгээ үйлчилгээний стандартын өндөр түвшинд үзүүлж, амжилттай хийсэн байна. | 100% |
| 15 | | 3. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг | 2022 - 2024 | Байгууллагын төсөв | 90 | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг салбарын хэмжээнд 4 зорилтын хүрээнд 8 ажил зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжих" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | | | байгуулж, жилийн эцсийн хэрэгжилт 92,5 хувьтай байна. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинет амбулаторийн тасгийн 214 тоотод үйл ажиллагаа явуулж, энэ оны 2 дугаар улиралд андрологийн нарийн мэргэжлийн эмч 1, мэргэшүүлсэн 2 сувилагчийг бэлтгэсэн. Бөөр шээсний доод замын оношилгоо, мэс заслын 9 нэр төрлийн 151,438,093 төгрөгийн дуран, тоног төхөөрөмжөөр хангагдан, жилийн эцсийн байдлаар нийт 102 иргэнд урологи, андрологийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Эрүүл мэндийн сайдын А/139 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх оношилгоонд аймгийн хэмжээнд 30243 иргэн хамрагдаж, 33.7 хувьтай байна. Нийт эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн 41.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчин Чихрийн шижин, Артерийн гипертензи өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 48682 иргэн хамрагдсанаас 28152 буюу 57.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Үүнээс артерийн даралт ихсэх өвчин 68, чихрийн шижин 9 илэрч, иргэдийг 100 хувь эмнэлгийн хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлсэн. | |
| 16 | 2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 1. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах | 2021 - 2024 | Жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 12,9 сая төгрөг | 70 | БЗДХ, ХДХВ, ДОХ-ын кабинет 3 их эмч, 2 сувилагч, 1 сайн дурын зөвлөгөө шинжилгээний зөвлөгч, 2 лаборанттай үйл ажиллагаагаа явуулж байна. Жилийн эцсийн байдлаар тэмбүү-130, заг хүйтэн-127, трихоминиаз-195 тохиолдол бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад тэмбүү-33, заг хүйтэн-109, трихоминиаз-159 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй, нийт 1328 жирэмсэн эхийг БЗДХ-ын шинжилгээнд хамруулахад тэмбүү-29, трихоминиаз-68, заг хүйтэн-1 илэрсэнийг 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн. Харъяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сүрьеэ болон БЗДХ-ын оношилгоо эмчилгээний стандарт сэдвээр чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 24 албан хаагч хамрагдсан. Сургалтын дараах мэдлэг 14 хувиар нэмэгдсэн. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | Байгууллагын төсөв | 3.5 | Сүрьеэгийн 29 тохиолдол бүртгэгдсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Сүрьеэгийн диспансерт 20 сумаас 782 сорьцийг тээвэрлэснээс 4 хүний 8 сорьц түрхэц эерэг гарч эмчилгээнд хамруулсан. Эрүүл мэндийн газрын 2023 оны А/50, А/97 дугаар тушаалаар үзлэгийн удирдамжийг баталж, хөтөлбөр болон эрсдэлт бүлгийн иргэдийн судлагааг гаргасан. | 70% |
| 18 | | 3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах | 2022 - 2023 | Гүйцэтгэлийн санхүүжилтээр | 100 | Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх оношилгоонд хагас жилийн байдлаар 24381 иргэн хамрагдаж 27,2 хувьтай улсын хэмжээнд 17 дугаарт байсан бол эрчимжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулснаар жилийн эцсийн байдлаар 31158 иргэн хамрагдаж 34,8 хувьтай улсын хэмжээнд 12 дугаарт байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/256 дүгээр тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн газраас эрт илрүүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх 2 сарын аян зарлаж, Төрийн болон аж ахуй нэгж байгууллагууд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамт олноор нь хамруулах ажлыг зохион байгуулж төрийн 10 байгууллагуудын 400 гаруй албан хаагчид хамрагдсан, 12 дугаар сард эрт илрүүлгийн үзлэгт 299 иргэн хамрагдсан байна. | 30% |
| 19 | | 4. Иргэдийг ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах | 2022 - 2023 | Гүйцэтгэлийн санхүүжилтээр | 2000 | Ковидын өвчлөлөөр 2023 онд нийт 203 тохиолдол бүртгэгдэж, хүндрэл нас баралт бүртгэгдээгүй. Үүнээс Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тасагт ковидын дараах хүндрэлээр 56 иргэн эмчүүлсэн. “Ковидын дараах иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх” төлөвлөгөөний биелэлт 95.2 хувьтай үр дүнтэй хэрэгжсэн байна. | 0% |
| 20 | 2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний | 2022 - 2024 | Гүйцэтгэлийн санхүүжилтээр | 200 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт дотрын мэргэжлийн 8 их эмч, хувийн хэвшлийн эмнэлэгт 5 их эмч, анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд 12 их эмч, нийт 25 эмч иргэдэд дотрын чиглэлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нэгдсэн эмнэлэгт ревматологийн чиглэлээр 3 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чанар хүртээмжийг сайжруулах | | | | шатлалд ажиллаж байсан 1 эмчийг орон тоогоор авч ажиллуулан, ревматологийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарч байна. 2023 онд 489 нярай хүүхдэд түнхний ЭХО үзэж, хэвийн 405, В хэлбэр 81, С хэлбэр 6, D хэлбэр бүртгэгдээгүй байна. | |
| 21 | | 2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 1500 | Аймгийн хэмжээнд 1474 эхээс амьд төрсөн 1487 нярайд эрт илрүүлгийн скрининг шинжилгээ хийхээс 1370 нярай үзлэгт хамрагдсан. Үүнээс: 1. хэвийн буюу type A 1127, 2. дутуу хөгжилтэй буюу type B 230, 3. мултрал буюу type C 13, type D оношлогдоогүй. 4. Хамрагдаагүй 24. Төрөлхийн сонсгол бууралт илрүүлэх шинжилгээнд хамрагдсан 1394. Хамрагдаж тэнцсэн 1308, Тэнцээгүй нярай давтан үзлэг -40 хийгдсэн. Сонсгол нийт 1308 хүүхдэд шалгасан. Үүнээс: 1. анхны үзлэг-1394, анхны үзлэгээс: 2 талд тэнцсэн-1308, 2 талд тэнцээгүй-28, зүүн чих тэнцээгүй-31, баруун чих тэнцээгүй-18. 2. давтан үзлэг- 40. Давтан үзлэгээс: 2 талд тэнцсэн-34, 2 талд тэнцээгүй-1 зүүн чих тэнцээгүй-2, баруун чих тэнцээгүй-3. Нэг чихний дэлбэнгийн гаж хөгжилтэй хүүхдийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлэн, эмчилгээ оношлогооны стандарт, удирдамжийг мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 22 | 2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана. | 1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх | 2021 - 2024 | | 0 | Эрүүл мэндийн анхан шатны 24 байгууллагад 2604 яаралтай түргэн тусламжийн дуудлага хүлээн авснаас 1167 алсын дуудлагад цаг хожимдолгүй үйлчилсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг багасгах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор цахим хуудас, дуудлага хүлээн авах, зөвлөгөө өгөх суурин утсыг 24 нэгжид тогтмол ажиллуулж байна. Амбулаторийн үзлэгийг 51676 иргэнд үзүүлж, тусламж үйлчилгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна. Иргэд нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлсэн эмчийн үзлэгийн цаг захиалга, эмнэлгийн магадлагаа, лабораторийн шинжилгээний хариу, цусны бүлгийн тодорхойлт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн дүгнэлт, эрүүл мэндийн даатгалын төлөлтийн мэдээллүүдийг E-Mongolia системээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан шууд харах боломж бүрдсэн. Амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг эрүүл мэндийн хөгжлийн төвийн дуудлагын нэгдсэн төвийн цаг захиалгын нэгдсэн системд холбосноор иргэд 1800-0119 дугаарт 2023 онд 6720 хүн эмчийн үзлэгийн цагийг утсаар авсан. Ингэснээр иргэд үзлэгийн цагийг хүлээгдэл чирэгдэлгүйгээр өөрийн боломжит цаг хугацааг сонгон үйлчлүүлэх боломжтой болсон | |
| 23 | 2.1.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Өвчтөний түүхийг цахимжуулж, E-Health программыг бүрэн нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 90 | E-Health цахим программын 13 модуль 600 цэсийг аймгийн Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн нийт 331 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж програм ашиглалт 100 хувь байна. Энэ онд E-Health программд өндөр өртөгт: бздх-pcr (rt-pcr үндсэн 7 үүсгэгч), бздх-pcr (rt-pcr мөөгөнцөр халдварын 7), бздх-pcr (rt-pcr нянгийн гаралтай 7), бздх-pcr (rt-pcr нянгийн гаралтай 7), а/з-pcr (rt-pcr амьсгалын зам), rt-pcr-hpv (rt-pcr-hpv), Бичил амь судлалын шинжилгээ шинжилгээг тус тус нэвтрүүлсэн. Оношилгоо шинжилгээ, дүрс оношилгооны багцад genexpert аппаратад хийгдэх шинжилгээ, плеврийн шингэн хтн, бронхын угаадас хтн, булчирхайн хтн, нугасны ус хтн, өтгөн хтн, үений шингэн хтн, цэрний хтн, шээсний хтн, хэвлийн шингэн хтн, хамрын дуран, чихний дуран, төвөнхийн дуран, хоолойн дуран, түнхний эхо, зулайн эхо зэрэг үйлчилгээний модиулуудыг шинээр нэвтрүүлэн ашиглаж, иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байна. Хэвтэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг цахим хэлбэрээр хөтөлж, цахим хувь үүсгэн хадгалдаг болсон. Ингэснээр тухайн өвчтний эрүүл мэндийн цахим дэвтэр үүсэх боломж бүрдсэн. Эрүүл Мэндийн Яам, Цахим Хөгжил, Харилцаа, Холбооны Яамнаас өгсөн чиглэлийн дагуу health.gov.mn, E-Health программаар 13А маягтыг анхан шатнаас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага хооронд цахимаар илгээх, хүлээн авах болон иргэд 13А маягт өөр дээр нь бичигдсэн эсэхээ төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аас харах нөхцөл бололцоог бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | | 2. Олон улсын эмнэлзүйн удирдамж Upto date программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 80 | Эмнэл зүйн олон улсын удирдамж “Up to Date” платформын ашиглалтыг нэмэгдүүлж, уг платформын явцын хяналтыг 4 удаа хийсэн. Жилийн эцсийн хяналт үнэлгээний шалгуурт оруулж үнэлсэн. Ажлын байранд платформыг нээх, ашиглалтыг сайжруулах зөвлөгөө мэдээлэл өгч Нэгдсэн эмнэлгийн 82 их эмчээс 66 эмч буюу 80 хувь нь, сум өрхийн 70 их эмчээс 52 эмч буюу 74 хувь, хувийн хэвшлийн 44 эмчээс 12 эмч буюу 27 хувь нь тус тус хэрэглэж байна. Нийт эмч нарын 60 хувь нь ашиглаж байна. Анхан шатны нэгжүүдээс Богд, Эрдэнэцогт, Баянговь эмч нарын ашиглалт сайн, шинээр 30 эмчид платформ программ суулгаж, ашиглах заавар зөвлөгөөг өгч 92 хувьтай болсон. | 100% |
| 25 | 2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 1. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр сургалтад хамруулах | 2021 - 2024 | | 900 | Хүний нөөцийг хөгжүүлэх чадавхижуулах чиглэлээр Үндсэн мэргэжлээр: гэмтэл судлал, дотор, хавдар судлал, Төрөлжсөн мэргэшлээр: Дотоод шүүрэл, харшил, хүүхдийн дотоод шүүрэл, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, клиник эм зүйч, нүдний жижиг зүслэгт болорын мэс засал, нүдний болорын дурангийн мэс засал, Дээшлүүлэх сургалтад: Хэвлийн ЭХО, эмэгтэйчүүдийн ЭХО зэрэг нарийн мэргэжлээр 12 эмчийг сургасан байна. Сувилахуйн чиглэлээр: Дотоод шүүрлийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилахуй, хүүхдийн сувилахуй, гэмтэл согогын сувилахуй, дархлаажуулалтын сувилахуй, хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй, нүдний болорын мэс заслын сувилахуй, Дээшлүүлэх: Нярайн сувилахуйн дээшлүүлэх, эх баригчийн мэргэжилээр дээшлүүлэх зэрэг 10 сувилагч тусгай мэргэжилтнийг бэлтгэсэн. Лабораторийн чиглэлээр: Дархлаа судлал, клиник биохими судлал, эд эс судлаачийг сургаж чадавхижуулсан. Гадаад сургалтад дотрын их эмч С.Уртнасанг Вьетнам улсад гемодиализ эмчилгээний чиглэлээр, сувилахуйн арга зүйч Г.Баярмааг БНХАУ-д сувилагч чадавхижуулах сургалтад, Япон улсад эх баригчийн сургагч багшаар Б.Баярхүү, Солонгос улсад сувилахуйн арга зүйч Б.Болормаа эх барихуйн сургагч багшаар тус тус бэлтгэгдсэн Хүний нөөцийн бүртгэл, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл, төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн зэрэг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, шалгалтын үйл ажиллагааны хүрээнд цахим платформд 66 байгууллага, 739 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бүртгэсэн. Хүний нөөцийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, харъяа эрүүл мэндийн байгууллагуудаас төлөөлөл оролцуулан ажлын хэсэг байгуулж, 2024 оны эхний хагас жилд багтаан стратеги төлөвлөгөөг батлуулахаар шийдвэрлэсэн. | |
| 26 | | 2. Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ёс зүйгээрээ бусдыгаа манлайлсан ажилтнуудыг урамшуулах, алдаршуулах | 2021 - 2024 | | 92 | 2023 онд "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат аяныг зохион байгуулж, аяны хүрээнд эмч, сувилагч, тусгай мэргэжилтний ёс зүйн харьцаа хандлагыг үнэлгээг 1390 үйлчлүүлэгчээс QR үүсгэн авч, дүгнэлт өгч ажилласан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн эерэг хандлага 92.4 хувьтай байна. Их эмчийн ёс зүй харьцаа хандлагыг 794 үйлчлүүлэгч үнэлж эерэг 91.3 хувьтай “сайн”, сувилагч, тусгай мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлагыг 596 үйлчлүүлэгч үнэлж эерэг 93.5 хувьтай “сайн” гэсэн дүгнэлт гарсан. Анхан шатны сумдын эрүүл мэндийн 20 байгууллагад 2023 оны үйл ажиллгааны гүйцэтгэлийн хяналт, үнэлгээг зохион байгуулж, ёс зүйн багийн үйл ажиллагаанд үнэлгээ өгсөн. Үнэлгээний явцад Заг, Баянбулаг сумын эрүүл мэндийн төвийн ээлжийн сувилагч 2 мэргэжилтэнд ярилцлага хийж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. "Бид Ёс зүйгээр манлайлна” аяны хүрээнд Олон улсын Сэтгэлийн боловсролын төвтэй хамтран “Хүний амьдралын үнэ цэнэ” сэдвийн хүрээнд Олон улсын Сэтгэлийн боловсролын төвийн лектор И Гон Сюу багшийг урьж, хувь хүний харьцаа хандлагыг сайжруулах, сэтгэлийн боловсролын үнэ цэнэ лекц, сургалтыг зохион байгуулж, лекц, сургалтад аймгийн Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтний төлөөлөл 140 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100% |
| 27 | | 3. Албан хаагчдын | 2021 - | | 90 | Салбарын хэмжээнд ажлын байрны Эмнэлгийн тусламж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах | 2024 | | | үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн эерэг хандлага 92.4 хувьтай байна. Их эмчийн ёс зүй харьцаа хандлагыг 794 үйлчлүүлэгч үнэлж эерэг 91.3 хувьтай “сайн”, сувилагч, тусгай мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлагыг 596 үйлчлүүлэгч үнэлж эерэг 93.5 хувьтай “сайн” гэсэн дүгнэлт гарсан. хамрагдаж мэдлэг мэргэшилээ дээшлүүлсэн. 2023-2024 оны хичээлийн жилд улсын төсвийн санхүүжилтээр төрөлжсөн мэргэжлээр 13 чиглэлээр 16 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэшил дээшлүүлэх сургалтад 7 чиглэлээр 7 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хаврын элсэлтэд суралцаж байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 124 эмнэлгийн мэргэжилтэнд 603,6 мянган төгрөг, 29.2 дахь заалтаар 42 эмнэлгийн мэргэжилтэнд 893,1 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон. Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 05, 395 дугаар тогтоолуудын хүрээнд салбарын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 863 албан хаагчид 91,0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал олгосон байна. Монгол улсын Төрийн одон медальд 16 албан хаагчийн материалыг холбогдох газруудад хүргүүлж, 15 албан хаагч шагналаа гардаж авсан. Урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд харьяа эрүүл мэндийн байгууллагын 986 буюу нийт албан хаагчдын 76,8 хувь нь хамрагдаж, урд оны мөн үетэй харьцуулахад хамрагдалт 2,0 хувиар өссөн байна. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 98 хувьтай байна. | |
| 28 | 2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, | 1. Амбулаторийн барилгыг шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | Улсын төсөв 3,8 тэр бум төгрөг | 90 | Нэгдсэн эмнэлгийн 9.4 тэрбум төгрөгийн өртөгтэй Амбулаторын шинэ барилгын ажлыг "Рокпэйнт групп" ХХК гүйцэтгэж, 2023 оны улсын төсөвт 3868,6 сая төгрөг батлагдаж, 12 дугаар сарын байдлаар барилгын гүйцэтгэл 70 хувьтай байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.000 гаруй хүн амд хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын шаардлагад нийцсэн ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэх юм. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ. | 2. Стандарт шаардлага хангасан хог хаягдлын байгууламжтай болох | 2023 - 2024 | | 50 0 | Стандартын шаардлага хангасан хог хаягдлын байгууламжийг 2022 онд ашиглалтад оруулж гүйцэтгэл 100 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 80 хувьтай байна . Хувийн хэвшлийн эмнэлэг, шүдний эмнэлгүүдтэй гэрээ хийх албан тоотыг 39 байгууллагад хүргүүлж 26 байгууллага хог хаягдлын менежментийн хүрээнд гэрээ хийж, хамтран ажиллаж байна. Үйл ажиллагаа гэрээний дагуу хэвийн үргэлжилж байна. | 100% |
| 30 | | 3. Эмгэг судлалын барилгыг шинээр барих | 2023 | | 100 | Нэгдсэн эмнэлгийн 402.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй эмгэг судлалын албаны байрны зураг төсөв хийгдэж, барилгын ажлын төсвийг 2023 оны төсвийн тодотголоор хэлэлцүүлэн батлуулж, энэ онд барилгын суурь тавигдаж барилгын гүйцэтгэл 20 хувьтай байна. Эмгэг судлалын албаны шинэ байрны асуудлыг шийдвэрлэснээр стандартад нийцсэн орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломж нөхцөл бүрдэж байна. | 30% |
| 31 | 2.1.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно. | 1. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох | 2021 - 2024 | | 7000 | Хувийн хэвшлийн 23 эмийн сангуудаас сар бүр жорын судалгаа авч, жилийн эцсийн байдлаар судалгаанд дүгнэлт гаргахад 15 байгууллагаас 25,012 ширхэг жор хүлээн авч үүнээс эмчийн тамгагүй жор 20%, өвчтөний нас хүйс бичээгүй жор 5%, оношийн код бичээгүй жор 4%, антибиотик эмийг жоргүй олгосон 4% эзэлж, зөрчил дутагдлыг тухай бүр илрүүлэн ажилласан. Мөн нийт 25,012 эмийн жорны 6600-н антибиотикийг жоргүй олгосон тохиолдлын тоог илрүүлсэн байна. Эмийн харилцан үйлчлэл, чанар аюулгүй байдал сэдэвт багц цагийн сургалтад 60 эмийн мэргэжилтэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Эмийн гаж нөлөөг хүн бүр мэдээлэх боломжтой болсон. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоногийн аянуудын хүрээнд аймгийн төвийн болон сумдын хувийн хэвшлийн эм зүйч, эм найруулагч нар 950 эмнэлгийн мэргэжилтэн, 8 албан байгууллага хамтран 1000 гаруй ард иргэдийг сургалт суртачилгаанд хамруулж, гарын авлага бэлтгэн тарааж витаминжуулсан байна. | 100% |
| 32 | | 2. Зайлшгүй | 2021 - | | 89 | Аймгийн хэмжээнд 49 эмийн сан тусгай зөвшөөрөлтэй | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаардлагатай эмийн үнийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх | 2024 | | 15 | байгаагаас нэгдүгээр зэрэглэлийн эмийн сан 13, хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан 36 байна. Стандартын дагуу эмийн үнийг шошгод 100 хувь байрлуулсан байна. Эрүүл мэндийн газрын удирдамжийн дагуу 2 багийн бүрэлдэхүүн нийт 16 эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын хэрэгжилт, антибиотик эмийг жороор олгож байгаа эсэх, хүний нөөц, ил тод байдал, эмийн үнийн тариф зэрэг үйл ажиллагааг хянан, зөвлөн туслах үйлчилгээг хүргэсэн. Хяналт үнэлгээгээр илэрсэн зөрчил дутагдлыг эмийн сангийн эрхлэгч нарт танилцуулж, заавар зөвлөмж өгч, хэрэгжилтийг зохион байгуулж, хянаж ажилласан. Сумдын эмийн сангуудын үйл ажиллагааг Эрүүл мэндийн газар, сумын ИТХ, эрүүл мэндийн төв, эмийн сантай хамтран ажиллах дөрвөлсөн гэрээгээр үнэлж дүгнэн, эмийн үнэ, эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна. | |
| 33 | 2.2.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах | 2022 - 2024 | | 50<br>500 | Спорт цогцолборын тоног төхөөрөмжийг Спорт цогцолборын тоног төхөөрөмжийг Улс, орон нутгийн төсөв, Улсын их хурлын гишүүн Г.Занданшатарын дэмжлэг, хандив тусламжаар 48 сая төгрөгний офиссын болон заалны тоног төхөөрөмжийн хангалтыг хийсэн. Тоног төхөөрөмжийн хангалт 60 хувьтай офисс болон заалны үйл ажиллагаа тогтмолжсон. 2023 онд нийт спортын чиглэлээр 33 үйл ажиллагаагаар давхардсан тоогоор 7598 иргэд хамрагдаж 120,000,000 төсөв зарцуулж нийт 33,615 иргэдэд хүрч ажилласан. Усан бассейныг ашиглалтад оруулж үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа тооцооллыг гаргаж Биеийн тамир,спортын улсын хороонд хүргүүлсэн. | 100% |
| 34 | 2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, | 2022 - 2024 | Орон нутгийн төсөв 10.0 сая төгрөг | 100 | "Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөнд туссан 4 зорилт арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна. Энэ хүрээнд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цаг гаргая” аянд 17368 хүн, “Энэ жилдээ Эрүүл жиндээ” аянд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | | хэрэгжүүлэх | | | | 6223 хүн, “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аянд 2509 хүн хамруулан зохион байгуулж аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 26.0 мянга гаруй иргэдийг хамруулж сумдын биеийн тамирын арга зүйч багш нарт үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан. Идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг иргэдийн тоо 3556 хүрсэн байна. | |
| 35 | | 2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 10.0 сая төгрөг | 20000 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Биеийн тамир, спортын газрын харьяа 11 заалаар иргэдэд үйлчлэх, Бүжгийн клуб, Иогийн клуб, Ширээний теннисний клуб, Шатар, Даамны клубуудыг заал танхимаар хангаж ажиллуулж нийт 40 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, 250 гаруй иргэнд тогтмол үйлчилж байна. Монголын хүүхдийн спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг спортын үндсэн 10 төрөл, сонгох 4 төрлөөр амжилттай зохион байгуулж аймгийн хэмжээнд 986 тамирчин оролцсон. орон нутгийн зардлаас 20.0 сая төгрөг зарцуулагдсан. “Монголын Бүжгийн Спортын Холбоо, Mongolian Dance Sport Federation, Баянхонгор аймгийн Бүжгийн Спортын “Энгүүн Холбоо”-той хамтран “Хангайн бүсийн аймгуудын аварга шалгаруулах “Бүжгийн спортын тэмцээн” зохион байгуулж 200 гаруй тамирчид, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цаг гаргая” аянд 17368 хүн, “Энэ жилдээ Эрүүл жиндээ” аянд 6223 хүн, “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аянд 2509 хүн хамруулан зохион байгуулж аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 26.0 мянга гаруй иргэд хамруулж сумдын биеийн тамирын арга зүйч багш нарт үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан. | 100% |
| 36 | | 3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | Шинээр ашиглалтад орсон 2 заалны төсөв 1,776,6 /улсын төсөв/, 2 | 2<br>1<br>0 | 2023 онд аймгийн хэмжээнд Бууцагаан сумын Баянбүрд багийн спорт заал,Шинэжинст сумын спорт заал нийт 2 заалыг бүрэн ашиглалтад оруулсан. Бөмбөгөр сумын спорт заалны барилгын гүйцэтгэл 80 хувьтай 2024 онд ашиглалтад орно. Дөвөнтийн заалны их засварын ажил, Баацагаан сумын спорт заалны засвар нийт 2 заалны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | заалны засвар 520,0 сая / улсын төсөв/ Гадна талбайн засвар: Хандив тусламж 1,1 тэр бум | | засвар хийж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Гадна талбай: Огтонотой булгийн спорт цогцолбор гадна талбайг шинээр ашиглалтад оруулсан. | |
| 37 | 2.3.1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 100 | Нийт 30 сургуулийн 50 хувьд нь орон тооны сэтгэл зүйч ажиллаж, хоцрогдол арилгахад эцэг эх, сургуулийн зөвлөлийн үүрэг оролцоог хангаж, цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлсэн. Сургуульд суурилсан үнэлгээнээс сурлагын амжилтыг 20 болон түүнээс илүү хувь ахиулсан 5 багшийг шалгаруулж урамшуулсан. 2022 онд 600, 2023 онд 600 багшид өндөр үзүүлэлттэй зөөврийн компьютерийг олгосон. БШУГ болон 6 сургуульд 21.0 сая төгрөгийн цахим сургалтын лаборатори, 650.0 сая төгрөгийн үнэтэй таблет бүхий цахим хэрэглэгдэхүүнээр 9 сургуулийг хангасан байна. Багш нар 265 цагийн контент бүтээж, 30000 гаруй тестийн сан бүрдүүлсэн Сурлагын хоцрогдол нөхөх, арилгахад 13 сургууль тус бүрд нийт 77 дэмжигч, 5 сургууль 38 явуулын, 8 дадлагын багш, зуны сургалтанд 219 багш хамрагдсан. Дотуур байрын багшийн үйл ажиллагааг сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад чиглүүлэн ажиллав. Хоцрогдол арилгаж буй сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш солилцоо, сургалт 10 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, багшийг Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах арга зүйгээр хангаж ажилласан. Сургуулийн менежментийг сайжруулах, үр дүнд суурилсан төлөвлөлтийг хийхэд сургууль цэцэрлэг бүрт сургалт явуулах, зөвлөн туслах, бусад сургуулийн сайн арга зүйгээс суралцах үйл ажиллагаа арга хэмжээг зохион байгуулан ажилласны үр дүнд сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 1 байранд эрэмбэлэгдлээ. Аймгийн ИТХ-аар тайланг хэлэлцүүлж төлөвлөгөөний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилт 100 хувьтай байна. | |
| 38 | | 2. "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 100 300 | Аймгийн Засаг даргын захирамжаар " Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөө" -баталж 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 92 хувьтай байна. Багшийн тасралтгүй хөгжлийг хангах зорилгоор "Мэргэжлийн бүлгийн зохион байгуулалтаар хамтран ажиллах арга зүй" сургалтыг 1200 гаруй багш ажилтанд зохион байгуулж үүний үр дүнд 130 гаруй мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжил дээшлүүлэх, цахим контент боловсруулах арга зүйн сургалтыг 800 гаруй багшид зохион байгуулснаар 311 цагийн онлайн хичээл бүтээж үндэсний цахим санд байршуулсан. "Сургуулийн менежментийг сайжруулах хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслахад дэмжлэг үзүүлэх, Орон нутгаас "Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх, үнэлгээ хариуцсан менежерүүдийн чадавхжуулах хөтөлбөр, төрөлжсөн хичээлүүдийн улсын олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш нарт 2021-2023 онд 100.0 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 600 багшид өндөр хурдны зөөврийн компьютер олгоход 1,4 тэрбум төг, дижитал анги 14 сургуульд байгуулахад 900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн . | 100% |
| 39 | 2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ. | 1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах | 2021 - 2024 | | 40 | Тэгш хамран сургах сургалтын хүрээнд хөжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх арга зүйн сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүдэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүйн сургалтыг 1 удаа цахим, 3 удаа танхимаар зохион байгуулсан. Тэгш хамран сургах боловсролын талаарх үндсэн ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжлэгийн багийн үйл ажиллагаанд анхаарах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулж үнэлэх зэрэг агуулгаар БЕГ, БШУЯ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга зүйч, багш, Насан туршийн төвийн багш нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулж, 92 багшийг сургалтад хамруулж мэргэжлийг дээшлүүлсэн. | |
| 40 | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, орчинг сайжруулах | 2021 - 2024 | НҮБ-Хүүхдийн сан 50 сая төгрөг | 2 | Өлзийт, Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургууль, Баянхонгор сумын "Номгон" ахлах сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танхим байгуулж 58 төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн, мөн хүүхдийн хөгжлийг сайжруулах 29 төрлийн тогтоолыг нийлүүлсэн. | 100% |
| 41 | 2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | 1. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 75 | "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 98 хувьтай хэрэгжсэн. Энэ хүрээнд  дараах ажлуудыг хийсэн зөв зохистой хооллолт, эрхтэн тогтолцооны хөгжил алдагдахаас урьдчилан сэргийлэх, бичил тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх сургалт, сургчилгааг зохион байгуулж нийт 4987 хүнд эрүүл хооллолтын зөв дадлыг төлөвшүүлэхэд нөлөөлж ажилласан.Олон улсын Эко-сургууль /цэцэрлэгүүдэд/ зориулсан Ахисан шатны 3 дахь сургалтанд амжилттай хамрагдаж Баянхонгор сумын 5,10,13,16-р цэцэрлэг, Шинэжинст, Бууцагаан сумдын цэцэрлэгүүд амжилттай хамрагдсан."Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Энэ ажлын хүрээнд 7000 гаруй хүүхдэд байгаль дэлхийгээ хайрлах төлөвшлийг олгож дадал хэвшил болгоход анхаарч ажиллаж байна. "МӨНГӨН ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 3, 6, 7, 12, Гурванбулаг сумын цэцэрлэг, "ХҮРЭЛ ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 5, 10, 13, 16, Өлзийт, Бууцагаан, Шинэжинст сумын цэцэрлэгүүд өргөмжлөлөө хүлээн авсан. мэргэжил арга зүйгээр хангахад чиглэгдсэн ISO14001 стандартыг сургалтын хөтөлбөртөө тусган ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | | 2. Бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчны сайжруулах | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 2 | Аймгийн хэмжээний төрийн өмчийн 36 цэцэрлэг зориулалтын гал тогоотой, 2022 онд 10 цэцэрлэгт 73, 2023 онд 10 цэцэрлэгт 80,9 сая төгрөгийн нийт 20 цэцэрлэгт 154,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэн ашиглагдаж байна. . | 100% |
| 43 | | 3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах | 2021 - 2024 | | 100 | Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг багш бүр даалгаврын аргачлал боловсруулан нийтдээ 39 хэрэглэгдэхүүний сан бүрдүүлж ажиллалаа. 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 5 настай хүүхдийн хамрагдалт 100 хувьтай байгаа нь улсын дунджаас дээгүүр байна. /улсын дундаж /94.4%/ 2023-2024 оны хичээлийн жилд статистик мэдээгээр 2077 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаас үндсэн бүлэгт 2124, хувилбарт сургалтад 130 хүүхэд 100 хувь хамрагдаж байна. | 100% |
| 44 | | 4. Хүүхэд харах төвийн үйлчилгээг тогтворжуулж, ясли байгуулах асуудлыг судлах | 2021 - 2024 | | 9 | Хүүхэд харах үйлчилгээ нь 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 3 хүүхэд харах төв ажиллаж 1,6-2 настай 175 хүүхдийг хүлээн авч ажиллаж байна. Түүнчлэн 2-3 настай хүүхдийг гэр бүлийн орчинд нь хөгжлийг дэмжих аргад эцэг эхийг суралцуулах сургагч багшаар 15 багшийг бэлтгэн эцэг эх хүүхдээ өөрөө асран хамгаалах цогц үйлчилгээ үзүүлэх боломж, ойлголт өгөх сургалтад хамруулсан. Японы засгийн газрын 2022 оны “Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд Бууцагаан сумын цэцэрлэгийн засварын төсөл”-ийг хэрэгжүүлж 90 хүүхдийн ортой цэцэрлэгийн хуучин барилгын их засвар хийснээр тус цэцэрлэгт 75 хүүхэд, үүнээс яслийн бүлэг нээн хичээллүүлж байна. . | 30% |
| 45 | 2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин | 1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 3 | Баян-Овоо сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга,“Номгон” ахлах сургуулийн 440 хүүхдийн өргөтгөл, Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургууль, Гурванбулаг сумын 160 хүүхдийн суудалтай сургуулийн барилга тус тус ашиглалтад орсон. 2023 онд Баацагаан, Богд, Баян-Өндөр, Баянхонгор сумын 5, 11, 12-р цэцэрлэгийн их засвар, Баянговь, Заг, Галуут, Баян-Овоо | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлнэ. | | | | | сумын сургуулийн дотуур байрны барилгын их засвар, хийгдэж барилгын стандарт нормыг мөрдөж эрүүл, аюулгүй тав духтай орчныг бүрдүүллээ. Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажлыг “Очиртзаан” ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажил 70 хувьтай явагдаж байна. Баянцагаан сумын 320 барилгын ажил 63 хувьтай, Богд сумын 150 хүүхдийн суудалтай дотуур байрны барилгын ажил 60 хувьтай байгаа. Баянбулаг сумын дотуур байрны ажил 50 хувьтай Заг сумын 160 хүүхдийн суудалтай барилгын ажил 30 хувьтай. 2023 онд аймгийн хэмжээнд нийт 2 сургууль бүрэн ашиглалтад орж, 1 сургуулийн өргөтгөл хийж, 1 цэцэрлэг бүрэн ашиглалтад орж, 6 цэцэрлэгийн их засвар хийж, 4 сургуулийн дотуур байранд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | |
| 46 | | 2. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 8 | БШУЯ ны хөрөнгө оруулалтаар “Модерн хаус” ХХК Бөмбөгөр сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байр, 100 хүүхдийн цэцэрлэгийн байр, Заг сумын сургуулийн 160 хүүхдийн хичээлийн байр , 80 хүүхдийн дотуур байр, 100 хүүхдийн цэцэрлэг, Баян-Өндөр сумын 320 хүүхдийн сургууль, 80 хүүхдийн дотуур байр, Баянбулаг сумын 90 хүүхдийн цэцэрлэгийн байрны барилгад ус ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулж 8 объектыг ашиглалтад оруулж үйл ажиллагаанд ашиглаж байна. Нийт 1,220.0 сая төгрөг. хөрөнгө оруулалт хийгдсэн. 3, 4 дүгээр ээлжийн Гурванбулаг сумын сургууль, цэцэрлэг, Хүрээмарал сумын дотуур байр, цэцэрлэг, Богд сумын сургууль, цэцэрлэг, Жаргалант сумын сургууль, цэцэрлэгийн зураг төсвийн магадлал хийгдэж тендер зарласан 10 ажил, 4 дүгээр ээлжийн зураг төсвийн ажил үргэлжилж буй 8 төсөлт ажил байна. Шинэжинст сумын сургууль цэцэрлэг, дотуур байрны ус ариун цэврийн байгууламжийг Эрдэнэ-монгол ХХК хийж гүйцэтгэлээ. Мөн НҮБ-ын Ус ариун цэврийн байгууламж төслийн хүрээнд Хүрээмарал, Гурванбулаг сумын сургуулийн дотуур байр, Баян-өндөр, Галуут сумын дотуур байр ариун цэврийн байгууламжтай болсон. Үүний үр дүнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт сургуулийн 74,7 хувь, дотуур байрны 76,7 хувь, хүүхдийн цэцэрлэгийн 91,1 хувь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай боллоо. | |
| 47 | | 3. Цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 2 | Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайн тоглоом нийлүүлэх ажил 26,490,000 төгрөгийн гадаа талбайн тохижилтын гэрээ хийгдсэн. Гэрээний дагуу гадна талбайн тоглоомыг 11 дүгээр цэцэрлэгт 12 сая 597 мянган төгрөгийн, 12 дугаар цэцэрлэгт 13 сая 800 мянган төгрөгийн тоглоомыг тус тус нийлүүлсэн. Цэцэрлэгүүд гадна тохижилт хийж тоглоомоо байршуулсан. Богд, Баян-Өндөр сумын цэцэрлэгүүд барилгын их засвар хийснээс гадна тоглоомын талбайг тохижуулж шинэ тоглоомын хэрэгслүүдийг суурилуулсан байна. 2023 онд аймгийн хэмжээнд нийт 4 цэцэрлэгийн гадна тохижилт хийгдсэн. | 100% |
| 48 | 2.3.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт “Үдийн хоол” олгох боломжийг бүрдүүлнэ. | 1. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 80 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй зорилтын хүрээнд НҮБ хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 30,5 сая /Эрдэнэмандал/ төгрөгийн тоног төхөөрөмж, Улсын төсвөөр Эрдэм, Соого сейкео, Номундалай, Политехник коллеж, Бөмбөгөр сумд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан. Эрдэм, Соого сейкео, Өлзийт сумын сургуулийн гал тогоо иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Аймгийн хэмжээнд нийт 30 сургуулийн 20 сургууль буюу 66,6 хувь нь зориулалтын хоол үйлдвэрлэлийн танхимтай, 10 сургууль нь буюу 33,3 хувь зориулалтын хоол үйлдвэрлэлийн заалгүй байна. Баянхонгор сумын Эрдэм сургуулийн хоол үйлдвэрлэл, урлагийн заалны өргөтгөлийн барилгыг 2024 онд эхлүүлэхээр улсын төсөвт суулгасан, Согоо сейко сургуулийн хоол үйлдвэрлэлийн танхимд 12.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж улсын төсвөөс олгосон. | 100% |
| 49 | 2.3.6. Насан туршийн | 1. Тэгш хамран сургах дүйцсэн | 2021 - 2024 | | 650 | Бичиг үсэг нөхөн олгох хөтөлбөрөөр 2022-2023 оны хичээлийн жилд 510 суралцагч суралцсанаас бага | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ. | хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх | | | | боловсролыг 11, суурь боловсролыг 64, бүрэн дунд боловсролыг 82 суралцагч эзэмшиж, Бага боловсролд 2, дунд, ахлах ангид тус бүр 1 суралцагч, нийт 4 суралцагч шилжин суралцлаа. Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд бичиг үсэг нөхөн олгох хөтөлбөрт 525 хүүхэд суралцаж байна. Үүнээс: эрэгтэй 403 буюу 77%, эмэгтэй 122 буюу 23% Малчин, малчдын хүүхэд 306, хийдэд шавилдаг 31, хөгжлийн бэрхшээлтэй 31, насны ангиллаар авч үзэхэд 8-14 насны 69, 15-18 насны 208, 19-наас дээш 248 суралцагчид хамрагдаж байна. 2023 оны Бичиг үсгийн сургалтад 207 иргэн хамрагдсан. Үүнээс: 151 эрэгтэй, 56 эмэгтэй буюу хүйсийн хувьд 73% эрэгтэй, 37% эмэгтэй эзэлж байна. Насны ангиллын үзүүлэлтээр 18 нас хүртэлх 25, 18-аас дээш насны 182 иргэн байна. Анхан 125, дунд 57, гүнзгий 11, ахисан шатанд 14 иргэн тус тус хамрагдаж, шинээр бичиг үсэг тайлагдсан 65, өмнөх түвшнээ ахиулсан 142 иргэн суралцан төгслөө. Сургалтад хамрагдсан иргэдээс малчин 89, хөгжлийн бэрхшээлтэй 40 үүнээс хараан 2, сонсголын 2, ярианы 6, сэтгэцийн 8, хөдөлгөөний 7, хавсарсан 15 байна. | |
| 50 | | 2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх | 2021 - 2024 | | 15000 2 | Аймгийн төвийн төрийн байгууллагуудад 38 сэдвээр 23 байгууллагаас 164 удаагийн захиалгат сургалтыг давхардсан тоогоор 973 албан хаагчид, нийт 114 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1753 албан хаагчид хамрагдсан. Энэ нь өмнөх оныхоос 1274 буюу 100% хувийн өсөлттэй хамруулсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчдэд 5 агуулгаар 6 сэдвээр 25 удаагийн давтамжтайгаар 1167 оролцогчдыг хамруулан тус тус зохион байгуулсан. Гэр бүл, гоо зүйн мэдрэмж, ёс суртахуун төлөвшил, иргэний боловсрол, амьдрах ухаан, санхүү, ажил мэргэжлийн чиг баримжаа, тогтвортой хөгжлийн боловсрол, мэдээлэл харилцааны технологи, шинжлэх ухаан, гадаад хэл үндсэн 14 чиглэлийн хүрээнд 1179 удаагийн сургалтад 31532 иргэн, 1242 нөлөөллийн үйл ажиллагаанд 22636 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн тус тус хамрагдаж, нийт давхардсан тоогоор 54168 иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлсэн. БЕГ-ын Насан туршийн боловсролын хэлтэс, E-Mongolia академитай хамтран Насан туршийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш нарын цахим ур чадварыг сайжруулах бүсчилсэн сургалтад нэгжийн менежер, төвийн багш нар 95% ирцтэйгээр 2 удаа хамрагдсан. Цахим боловсролын 30 цагийн хөтөлбөрт сургалтыг 25-45 насны 10-аас доошгүй иргэдэд зохион байгуулах чиглэлийг сумдын Насан туршийн боловсролын нэгжид өгч ажиллав. Хөтөлбөрт сургалтад 352 иргэн хамрагдаж өдөр тутам хэрэглэдэг гар утас, компьютер зэрэг ухаалаг төхөөрөмжүүдийг ашиглан цахим орчинд өөрийн хэрэгцээ шаардлагыг ханган интернэт банк ашиглах, хэрэглээний төлбөр төлөлт хийх, төрийн үйлчилгээг гар утаснаасаа E-mongolia нэгдсэн системийг ашиглах чадварт бүрэн суралцлаа. | |
| 51 | 2.3.7. Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэнэ. | 1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах | 2021 - 2023 | | 400 | Политехникийн коллежийг 2,5 жилтэй 13 мэргэжлийн 246 суралцагч төгссөн бөгөөд үүнээс 53,5 % нь ажлын байраар хангагдаж үүнээс барилгын салбарт /БӨУ, БЗЧ, Мужаан, Сан, Цахилгаан/ 18.2 хувь, үйлчилгээний салбарт /Үсчин, Авто, Хоол үйлдвэрлэл, Ардын гоцлол хөгжим/ 19,9 хувь, Хөнгөн үйлдвэрлэлийн салбар /Оёдол/-5.2 хувь байна. 2023 оны 4, 5 сард 45 хоногийн түр сургалтыг Баянхонгор аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулж 8 мэргэжлээр 145 хүн хамруулан үнэмлэх олгосон үүнээс 75% нь ажлын байраар хангагдсан. | 100% |
| 52 | 2.3.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, | 1. "Онлайн кабинет" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Улсын төсөв | 5 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд цахим орчныг бүрдүүлж, 642,0 сая төгрөгийн өртөг бүхий Дижитал ангийг Баянхонгор сумын Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соогоо сейкео, Гэгээн сумади сургууль, Бууцагаан, Өлзийт, Бөмбөгөр, Жаргалант, Баянбулаг, Галуут, Эрдэнэцогт зэрэг нийт 14 сургуульд байгуулж, ухаалаг самбар, бичил лаборатори ЕБС-иудад нийлүүлж сургалтын орчныг бүрдүүлсэн. Баацагаан сумын сургуульд 30.0 сая төгрөгийн лингофон цахим кабинетыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургуулийн орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ. | | | | | байгуулан ашиглаж байна. Шаргалжуут тосгоны сургуульд 90.0 сая төгрөгийн өртөг бүхий дижитал кабинетыг Шаргалжуут рашаан сувилал нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулж интернэт холбогдлоо. | |
| 53 | | 2. Багш нарыг компьютер, таблетаар хангах | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 300 | Багш нарыг зөөврийн комьпютерээр хангах үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын Ерөнхий газраас аймгийн ЗДТГ-аар дамжуулан Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж компьютержуулах нийт 1497,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 100 хувь 600 компьютер нийлүүлж дуусгасан. Үүнээс: Зөөврийн компьютер 1,385.9 сая, цахим контентын лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж 111,1 сая төгрөгөөр нийлүүлсэн. Цахим контент лаборатори байгуулахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Санкомаркетинг монголиа ХХК-тай гэрээ байгуулж нийт 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 100 хувь нийлүүлж дуусгасан. ЕБС-ийн 2022 оны санхүүжилтэд нэмэлтээр нөхөн хангалтын санхүүжилт 963,6 сая төгрөг суугдаж БШУС-ын 2022 оны 11 сарын 21-ны 1а/5624 тоот чиглэлийн дагуу хүүхдийн тооноос хамаарсан 1 толгой компьютер болон сурагчийн сургалтын таблетаар хангах цахим сургалтын тэнхим бүрдүүлэн ажилласан. Багш нарыг компьютержуулах ажлын хүрээнд 2024 оны улсын төсөвт 600 багшийн зөөврийн компьютерын үнэ болох 1,5 сая төгрөгийг шийдүүлж аймгийн хөгжлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд оруулсан тендерийн техникийн тодорхойлолт хийгдэж байна. | 100% |
| 54 | 2.4.1. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн үйл ажиллагааг сайжруулна. | 1. Сургалтын орчныг сайжруулж, боловсон хүчнийг чадавхжуулах | 2021 - 2024 | | 150 сая | Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн менежментийг өөрчилж Хөдөө аж ахуйн их сургуулийн салбар сургууль болгон өөрчилж улирлын болон эчнээ ангиудыг нэн шаардлагатай мэргэжлүүдээр нээн элсэлт авч байна. Сургуулийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж зураг төсөв хийгдсэн. Баянхонгор аймагт ХААИС-ийн салбар сургууль бий болж байгаатай холбоотой ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль, Мал аж ахуй, биотехнологийн сургууль , Боловсрол, шинжлэх ухааны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар, Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран ажиллах гэрээ байгуулж аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр элсэлт авч хичээллүүлж байна. 2023-2024 оны хичээлийн жилд 125 суралцагч суралцаж байна. | |
| 55 | 2.4.2. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, жижиг дунд үйлдэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | 1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 100 | "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг Нийгмийн түншлэлийн сүлжээ" төрийн бус байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулж, бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгч 320, хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч 120, нийт 440 иргэнд аж ахуй эрхлэгчдэд зөвлөгөө өгч, бизнесийн төсөл, төлөвлөгөө боловсруулах мэдлэг олгосон. Мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх онол, дадлагын хосолсон сургалтад 35 эмэгтэйчүүдийг хамруулж, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийн кетельчин мэргэжил эзэмшүүлсэн. | 100% |
| 56 | 2.4.3. Шинэ мэдлэг, патент гаргасан эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн судалгааг гарган бүртгэлжүүлж, урамшуулна. | 1. Эрдэм шинжилгээний багийг байгуулж, шинэ мэдлэг патентийг бий болгох | 2022 - 2024 | | 4 | Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 захирамжаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн дүрмийг тус тус баталсан. Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан “Монголын инновацийн 7 хоног-2023” арга хэмжээ, “Инновацийг орон нутагт” сэдэвт мэргэжил, арга зүйн семинарт аймгийн Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар оролцлоо. Хангайн бүсийн инновац шалгаруулах уралдаан Баянхонгор аймгийн Өлзийт Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн Био Эрчим хүчний мод төсөл, Эрүүл хүнс үйлдвэрлэх, органик бордоог хэрэглэх төсөл, Сүү боловсруулах үйлдвэрлэл Олон улсын стандартад нийцсэн хатаах сүүний үйлдвэр тус тус оролцож уралдаанд шилдэг 9 бүтээлийн нэгээр Баянхонгор аймгийн "Шингэн бордоо" төсөл шалгарч 20.0 сая төгрөгийн грант авлаа. 2023 онд Оюуны өмчийн газраас Баянхонгор аймгийн иргэн хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй 37 патент болон барааны тэмдэгтийн мэдээлэл ирүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 2.5.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна. | 1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажлын байр бий болгох, ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулах | 2021 - 2024 | Баянхонгор сумын ОНХС-ын 200,0 сая төгрөг | 500 | Аймгийн бүтээн байгуулалтын ажлууд буюу ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, хог хаягдал ангилан ялгах, засмал зам дагуух хайрга чулууг түүх, динозавртай паркийн хашааг буулгах зэрэг аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд түр ажлын байранд 1425, байнгын ажлын байранд 567, нийт 1992 иргэн ажлын байраар хангагдсан. Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо өмнөх оноос 32.2 хувиар өссөн. | 100% |
| 58 | 2.5.2. Өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 250 | Ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, сурталчлах ажлын хүрээнд 5 арга хэмжээ, 6 сургалт, нийт 11 удаагийн томоохон арга хэмжээ, сургалт зохион байгуулж, 2322 иргэнийг хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 3029 иргэн хамрагдаж 1.668.1 сая төгрөгийг зарцуулж 1751 байнгын болон түр ажлын байр бий болж, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 5.9 хувиар өсөж, ажилгүйдлийн түвшин 2022 онд 15.5 хувь байсан бол 2023 онд 9.5 хувь болж 6 хувиар буурсан. | 100% |
| 59 | 2.5.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 1. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулж, нийгмийн баталгааг хангах | 2021 - 2024 | | 7820 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч ажил хөдөлмөр эрхэлдэггүй 4877 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 108, нийт 4985 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 4985 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 3358, хувиараа хөдөлмөр эрхлэгч 968, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 295, оюутан 83, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 108 байна. Сайн дурын даатгалд шинээр 372 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 114 хүнээр буюу 30.6 хувиар өссөн. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | 2.5.4. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 1. Хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах | 2021 - 2024 | | 200 | Амьжиргааны баталгаажих түшингээс доогуур орлоготой, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны ажил, хөдөлмөр хийх боломжтой давхардсан тоогоор 1425 иргэнд 570.0 сая төгрөгийн урамшуулал олгож түр ажлын байранд зуучилсан. Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо өмнөх оноос 32.2 хувиар өссөн. | 100% |
| 61 | 2.5.5. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" | 2022 - 2024 | | 10000 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор ирээдүйн өв сангийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журмын дагуу “Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" зорилтыг дэвшүүлэн ажилласан. Уг тогтоолыг Засгийн газрын 2023 оын 01 сарын 05-ны өдрийн 11-р тогтоолоор хүчингүй болгож хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам шинэчлэгдсэн иймд тус арга хэмжээ хэрэгжээгүй болно. Аймгийн хэмжээнд тус оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 35015 хүүхдэд 37.449,3 сая төгрөгийг цаг хугацаанд нь олгон ажилласан. | 0% |
| 62 | 2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, | 1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 8 | Баянхонгор аймгийн хэмжээнд Улс, аймгийн хамгаалалтай Түүх, соёлын 72 үл хөдлөх дурсгалт газрыг ойролцоо нутагладаг 81 малчин иргэнд гэрээгээр хариуцуулж соёлын төв, багийн Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан сурталчлан таниулах арга хэмжээнд 2.0 сая төгрөгийг | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна. | | | | | зарцуулсан | |
| 63 | | 2. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх | 2021 - 2024 | | 45 | Чин сүжигт номун хан сүм музейд хадгалагдаж байгаа XVII-XIX зууны үед хамаарах Ламын гэгээн Ханчинчойном жолбо буман зарлигаас бодь мөрийн зэргийн хөтөлбөр, оюуны мунхагийн хураангуй арилгах судар, Ламын гэгээний зурхан судар, Ламын гэгээний буман зарлигийн бодь мөрийн зэрэг, Их сангийн тийз, Тай нурууны гэрэлт хөшөө, 3 иргэний гар дээр хадгалагдаж буй XVII зууны үед хамаарах Төвд барын судар-2, Жадамба судар-1 зэрэг нийт 8 соёлын баримтад өвийг бүртгэн аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд оруулсан. | 30% |
| 64 | | 3. Биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах | 2022 - 2024 | | 3 | Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 40 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид бөгөөд таван хошуу 660 малтай нүүдлийн уламжлал, шашин-соёлын тоглолтын баг нийт 82 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Ламын гэгээний шашин-соёлын өвийг хослуулан бэлтгэсэн урлагийн тоглолтод “Жотлой” хүүхдийн найрал дуу, 8 хүүхдийн гарын бүжиг, гүр дуу, 5 дарь эхийн бүжгийг Хөгжимт драмын театрын уран бүтээлчид, Гонгандан дэдлин хийдийн хамба, урлаач, зурхайч нартай шашин номын уншлага ая данг хослуулан сэргээн үзүүлсэн. Монголчуудын мал маллах арга ухааныг сэргээж, 660 таван хошуу малыг тууварлан очсон бөгөөд монголчуудын уламжлалт нүүдэл хийх соёлын биет бус өвийн хүрээнд сарлагийн нүүдлээр сэргээн үзүүлсэн. -Аймгийн хэмжээнд биет бус өвийг хамгаалах түгээн дэлгэрүүлэх шавь, сургалт, уралдаан тэмцээнийг 40 удаагийн ажил арга хэмжээ зохион явуулж үүнд 3,0 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа. | 100% |
| 65 | 2.6.2. Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах | 1. Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах | 2021 - 2024 | | 70<br>170 | Соёл, урлагийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 4 удаагийн сургалт зохион байгуулж, нийт соёл урлагийн 408 ажилтан албан хаагчийг хамруулж чадавхжуулсан. Орон нутгийн төсвөөс мэргэжлийн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор соёлын салбарын ажилтан албан хаагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж 2023 онд 4 хүнд 9.9 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчин нөхцлийг сайжруулна. | | | | | сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн хүний нөөцийн хангалт 70 хувьтай байна. | |
| 66 | | 2. Соёлын төвийн бүтэц орон тоог нэмэгдүүлэн соёлын өвийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх | 2022 - 2023 | | 6 | Баянговь, Жаргалант, Баянцагаан, Баацагаан, Өлзийт, Баянлиг, Богд, Шинэжинст, Заг 9 сумдын Соёлын төвийн өвийн ажилтны орон тоог Соёлын яамтай зөвшилцөн бүтэн 6 орон тоогоор шийдвэрлэж 09 дүгээр сарын төсөвт цалин нэмэгдэл 68215.1 мянга төгрөгийг бүрэн суулгасан. | 100% |
| 67 | 2.6.3. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 | Орон нутгийн төсөв 10,7 сая төгрөг | 70 | "Соёлтой хонгорчууд” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 31 арга хэмжээгээр боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилт 51,2 хувьтай байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/407 захирамжаар батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд бүх нийтийн соёлын боловсролыг түгээх арга хэмжээг Соёлын сэргэлт, Соёлын бүтээлч сар аяны хүрээнд хүний хөгжлийн үечлэл бүрд чиглэсэн Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, түгээх “Соёлын хөтөч”-ийг залуучууд-20, Гэр бүл-10, ахмад-10 нийт 50 хүнийг Баянхонгор сумын 10 багт бэлтгэн чадавхжуулсан. Бүх нийтийн соёлын боловсрол, Соёлтой хонгорчууд арга хэмжээний хүрээнд 115 арга хэмжээг зохион байгуулж, 16720 хүнд хүргэж ажилласан. | 100% |
| 68 | 2.6.4. Соёлын төвүүдийн орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Соёлын төвүүдийн барилгыг шинэчлэх, иргэдийг соёлын боловсролын судалгааг хийх | 2021 - 2024 | | 0<br>40 | Аймгийн хэмжээнд Хүрээмарал сумын соёлын төв (240 хүний суудалтай) барилгын гүйцэтгэл 100 хувь, санхүүжилт 179,2 сая, Баянлиг сумын Соёлын төв (240 хүний суудалтай) барилгын гүйцэтгэл 100 хувь, санхүүжилт 914,5 сая, Өлзийт сумын Соёлын төв (240 хүний суудалтай) барилгын гүйцэтгэл 100 хувь санхүүжилт 692,7 сая төгрөгийн шийдвэрлэж бүрэн ашиглалтад оруулсан. Баацагаан сумын соёлын төвийн их засварын гүйцэтгэл 100 хувьтай. Нийт 3 сумын соёлын төв бүрэн ашиглалтад орж, 1 сумын соёлын төвийн их засвар хийсэн. Аймгийн Музейн шинэ барилгын газрыг Баянхонгор сумын Эрдэнэмандал багт 4100 м2 газарт кадастрын зураглал хийж, төсвийг шинэчлэн 7,415,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр боловсруулан Соёлын яаманд хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | | 2. Зарим сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимыг өргөжүүлэх | 2022 - 2023 | Орон нутгийн төсөв | 1 | Аймгийн хэмжээнд 18 сумын соёлын төв орон нутгийн судлах танхимтай. Баян-Овоо сумын Музейн барилгын ажил 2022 онд орон нутгийн хөгжлийн сангаас 298,0 сая төгрөгийн санхүүжилтээр шийдэгдэж орон нутгийн судлах танхимтайгаар баригдаж байна. Барилгын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна. | 0% |
| 70 | | 3. Соёлын төв, мэргэжлийн урлагын байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах | 2021 - 2024 | | 2 | Нийтийн номын санд чөлөөт уншлагын танхимыг амралтын болон оройн цагаар ажиллахаар төлөвлөж, 2023 оны 11 дүгээр сарын 01-ээс эхлэн ажиллаж эхэлсэн. Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд Орон нутгийн төсвөөс 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр Тэмүжин театрт үзэгчдийн сандал 300 ширхэг, Хөгжимт драмын театрт гэрэлтүүлэг, техник хэрэгслийг хүлээлгэн өгсөн. Хүрээмарал, Баянлиг суманд орон нутгийн төсвөөс 80,0 сая төгрөгөөр техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн. Нийт мэргэжлийн урлагийн 2 байгууллага, 2 сумын соёлын төвийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан. | 100% |
| 71 | 2.6.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 1. Иргэдийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | 90<br>1.5 | “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийн дагуу Нийтийн номын сан, Соёлын төв, Соёлын ордны 20 байгууллагаас сум, багийн Засаг дарга, Тамгын газар, Боловсролын байгууллага, Зохиолчдын холбоотой хамтран, иргэд олон нийтэд “Номын баяр-2023”- арга хэмжээг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд нийтийн номын сангийн ажилчид хангайн бүсийн 8 сум, төвийн бүсийн 3 сумдад тус бүр нэг өдөр “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг зохион байгуулж мэдээлэл сургалт, сурталчилгааны чиглэлээр 32 төрлийн арга хэмжээ, үзүүлэн таниулах чиглэлээр 167 төрлийн үзэсгэлэн, 4 төрлийн уралдаан тэмцээнийг 88 удаагийн давтамжтайгаар, уулзалт хэлэлцүүлэг 38 удаа зохион байгуулж, номын үзэсгэлэн, худалдаагаар нийт 420 орчим нэр төрлийн номоор үйлчилж давхардсан тоогоор 7224 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулснаас статистик тоо, номын сангийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | программын мэдээлэл дүнгээс харахад 3810 хүн аймгийн хэмжээний номын сангаар тогтмол үйлчлүүлж ном унших дадал хэвшилтэй болсон байна. | |
| 72 | 2.6.6. Аймгийн түүхийн музейн барилгыг барьж биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна. | 1. Хөдлөх дурсгалын мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 | | 800 | Аймгийн музейн үзмэр авах, худалдан авах зөвлөлийн 4 удаагийн хурлаар хүрлийн үеийн чулуулаг, зэв, чулуужсан яс, сумын зэв хүрэл дүрс, модон таваг, чулуужсан мод, зэрэг 70 үзмэрээр сан хөмрөгөө баяжуулан хувийн дугаарыг материалд тохируулан тавьж үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд бүртгэн баримтжууллаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар 70 ширхэг үзмэрийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, 3,3 сая төгрөгөөр худалдан авалт хийж, сан хөмрөгөө баяжуулж, нийт 10936 үзмэр эд өлгийн зүйлтэй болсон байна. | 90% |
| 73 | | 2. Биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 | | 11 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газрын даргын 2023 оны 09 сарын 22 ны А/33 дугаар тушаалаар Соёлын биет бус өвийн хангай бүсийн аймгийн үзлэгийг Баянхонгор аймагт 2023 оны 10 сарын 18-наас 30 ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг үзлэг судалгааг “Цахим суварга ТББ”, соёл судлалын ухааны доктор Л.Пүрэвлхам нартай хамтарч хийсэн аймгийн хэмжээнд 202 өвлөн уламжлагчтай бүртгэгдсэн бөгөөд үүнээс 12 сумын 62 өвлөн уламжлагчдыг хамруулан 38 өвлөн уламжлагчийг илрүүлэн шинээр бүртгэн баримтжуулалт хийж аймгийн музейн бүртгэл мэдээллийн санг 18%-иар нэмэгдсэн. | 100% |
| 74 | 2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, | 1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" зорилтот төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 5500 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлын уялдаа холбоог нягтруулж, сургалтын үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх, сурагч, багш, эцэг эхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг сэргээн идэвхжүүлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг дэлгэрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үр дүнд хүргэх зорилгоор "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" 5Х-ийн зорилтот арга хэмжээг боловсролын салбарт хэрэгжүүлэн ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд "Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдааныг зарлан явцын хяналт үнэлгээг 40 шалгуур үзүүлэлтийн дагуу сонгогдсон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцлагыг нэмэгдүүлнэ. | | | | | Гурванбулаг, Баянцагаан суманд үнэлгээ хийсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/307 тоот "Хүүхэд хамгааллын баг" шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай захирамж, болзолт уралдааныг 40 шалгуур үзүүлэлтийн дагуу хийж шалгаруулсан. Тус шалгуур үзүүлэлт бүхий ажилд хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд ЕБС-ийн 4278 хүүхэд, СӨБ-ийн насны 1938 хүүхэд нийт 6216 хүүхэд хамрагдсан. | |
| 75 | | 2. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 2500 | Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг нийт 33 сургууль, 43 цэцэрлэг, 12 байгууллага, сумдын төрийн байгууллагуудын 1583 эцэг эхэд үзүүлж, хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамруулсан. Арга хэмжээний үр дүнд эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг нэмэгдсэн. Иргэд гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, эрүүгийн хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, архидалтаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болсон. | 70% |
| 76 | | 3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | 2021 - 2024 | | 70 | Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг “Оролцъё-Хөгжье-Хамгаалагдъя” уриан дор 2023 оны 11 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хүүхдийн нэгдсэн чуулганд 18 сумын 30 ерөнхий боловсролын сургуулийн нийт 260 хүүхэд, 37 үүрэг хүлээгчид оролцсон. Чуулган зохион байгуулсны үр дүнд хүүхэд нийгмийн амьдралд оролцох, хөгжих эрхээ хэрэгжүүлэн, хүүхэд бүрийн оролцоог ханган ажилласан төдийгүй хүүхдүүд орчин тойрондоо тулгамдаж буй асуудлаа тодорхойлон шийдвэр гаргагч түвшний хүмүүст хандан асуудал шийдлийн талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн. Чуулганы төлөөлөгч хүүхдүүдээс гарсан 34 саналыг шийдвэр гаргагч түвшний хүмүүс сонсож 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой асуудлуудыг шийдвэрлэхээ илэрхийлсэн. 2022 оны чуулганаас гарсан саналын шийдвэрлэлт 70 хувьтай. | 70% |
| 77 | | 5. 4 настай хүүхэдтэй аавуудад | 2021 - 2024 | | 50 | Орон нутгийн 19 сумдад СӨБ-ийн 4 настай хүүхэдтэй аавуудад чиглэсэн сургалтын тусгай хөтөлбөрийг 2 зорилт 8 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх | | | | арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан ажилласан. Нийт 19 сумын 120 аавуудад бага насны хүүхдийн цогц хөгжил, 4 настай хүүхдийн насны онцлог, асаргаа халамж, тархины хөгжил, хоол тэжээл, хүүхдийн хүмүүжилд аавуудын үүрэг оролцоо сэдвээр мэдлэг олгож, аавуудад гэр бүлийн эрүүл мэнд, зөв зохистой хооллолт, эрүүл гэр бүлийн дадал, хорт зуршлаас ангид байх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, аавуудад альфа үеийн хүүхдүүдийн онцлог сэдэвт тараах материал, бага насны хүүхдийн зан байдлыг оношлох тестүүдийг тараан өгч тест ажиллах арга зүйд сургасан. | |
| 78 | 2.8.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. | 1. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | 60 | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 24 арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн Засаг даргын 2022 оны А/265 захирамжаар батлуулан сумдад хүргэсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж нийт 6735 хүнд хүрсэн. Сургалтад хамрагдсан иргэдийг хүйсээр ангилвал эрэгтэй 2753, эмэгтэй 3982 байна. ГХУСАЗСЗ, ЦГ-тай хамтран зохион байгуулсан "Амар тайван гэр бүл" нэгдсэн өдөрлөгийн хүрээнд сумдад ажиллахдаа 2022 онд "Гэр бүлийн боловсрол олгох" сургалтын сургагч багшаар бэлтгэгдсэн 48 хүнийг идэвхжүүлэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. "Хуримын ордон" 2023 оны 03 дугаар сард ашиглалтад орж "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Зөвлөгөө өгөх төвөөр 162 хүн үйлчлүүлж ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө авсан байна. Төлөвлөгөөний биелэлт 100% байна. | 100% |
| 79 | 2.8.2. Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн | 2. Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төв, сумдад загвар төв | 2022 - 2024 | | 2 300 | "Хуримын ордон" ашиглалтад орж "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийг байгуулж, MNS 6417:2013 стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Зөвлөгөө өгөх төвд ЗГХА-ГБХЗХГ-аас 25.405.000 төгрөгийн санхүүжилтээр стандартын дагуу техник, тоног төхөөрөмжүүдийг авсан. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна. | байгуулах | | | | Зөвлөгөө өгөх төвөөр 115 насанд хүрэгч, 68 хүүхэд, 12 гэр бүл / хүйсээр ангилвал 77 эрэгтэй, 124 эмэгтэй/ нийт 201 хүн үйлчлүүлж ганцаарчилсан болон хосын сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авсан байна. Зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийн 12 хүнийг өмгөөллийн үйлчилгээнд, 14 хүнийг түр хамгаалах байранд, 1 хүнийг Өвөрхангай аймгийн ГБХЗХГ-т, 28 хүнийг сумдын хамтарсан багуудад холбон зуучилсан. Зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх дэвтэр нээн тогтмол бүртгэж байна.Богд, Баянбулаг сумдын аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн дэмжлэгээр зөвлөгөө өгөх зан үйлийн төвийг байгуулах ажил эхэлсэн. | |
| 80 | | 3. Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 190 | Гэр бүл судлалын мэргэжлийн холбоо, орон нутагт бэлтгэгдсэн гэр бүл судлалын магиструудтай хамтран “Ханьтайгаа хамт амьдрал жаргалтай” өдөрлөг, “Хайрын холбоо” өдөрлөг, гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг үе шаттайгаар 20 суманд зохион байгуулж, 8 сумын гэр бүл судлалын холбооны гишүүн, гэр бүл судлалын магиструудтай хамтран ажилласан байна. Сургалт, өдөрлөгт нийт 89 залуу гэр бүл, 762 залуу хамрагдсан. Сургалт, өдөрлөгийн арга хэмжээнд хамрагдсан гэр бүлүүд хүүхэд хүмүүжлийн эерэг арга, угийн бичиг хөтлөх арга зүй, өрхийн төсөв хөтлөх аргачлал, эрүүл амьдрах хэв маягт суралцсан үр дүнтэй байна. | 100% |
| 81 | 2.8.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга | 2. "Хариуцлагатай 100 залуу элч"- ийг бэлтгэх | 2021 - 2024 | | 8000 | “Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал” төслийн хүрээнд Эрдэнэцогт, Баян-Овоо, Өлзийт сумдын 320 залуучуудад сургалт нөлөөллийн ажил, "Бүгд залуусын төлөө – Залуус бүгдийн төлөө" төслийн хүрээнд аймгийн залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 ТББ-ын төлөөлөл, төрийн байгууллагуудын залуучууд нийт 75 залууд чадавхжуулах сургалт, бодлогын хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийн суурь ур чадвар болох зөөлөн ур чадварын сургалтыг “Эм Эс Девелопмент” ХХК-ны дэргэдэх мэргэжлийн сургалтын төвтэй хамтран 275 залуучууд, ажил хайгч иргэдэд хувь хүний хөгжлийн ур | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | чадвар, харилцаа, сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулж 8,1 сая төгрөг зарцуулсан. | |
| 82 | 2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ. | 2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 80 | Салбар хорооны хурлыг 2 удаа цахимаар 2 удаа танхимаар зохион байгуулсан. Жендэрийн үндэсний хороо, аймгийн салбар зөвлөл хамтран 5 аймгийн 30 албан хаагчийг хамруулан анхан шатны сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, аймаг тус бүрээс 2, Баянхонгор аймаг 9 сургагч бэлтгэж, чадавхжуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт, төсөвлөлт сургалтад тусгайлсан чиг үүргийн цэргийн анги, шүүх, цагдаа, онцгой байдлын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 35-40 албан хаагчдыг хамруулан чадавхжуулсан. Жендэрийн үндэсний хороотой хамтран жендэрийн сургагч 9 багшийг бэлтгэсэн ба Өлзийт, Баян-Овоо, Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар, Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн албан хаагчдад сургагч багш нар 2 баг болж, сургалт зохион байгуулахаар төлөвлөж, хөтөлбөр , гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэн ажиллаж байна. | 50% |
| 83 | 2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана. | 1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 800 | “Өвгөнжаргалант” хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн 6 ээлжинд 712 хүүхэд, 70 насанд хүрэгч нийт 782 хүн хамрагдсан. Хөгжлийн хөтөлбөрүүд: -“Эгшиглэнт аялгуу” хөгжмийн ээлж -“Бид ирээдүйн ээзд” хүүхдийн ээлж -“Оролцоод хөгжье-Бусдаас суралцая” спортын ээлж -“Тэгш оролцоо-Тэгш хөгжил” майхант цугларалтын ээлж - “Аав, ээж, би” гэр бүлийн ээлж -“Хөдөлмөр зуслан” зэрэг болно. Эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд хүүхэд эх орныхоо түүх соёл, үндэсний өв уламжлалаа мэдэх, эх орonч сэтгэлгээтэй болох, өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болсон. Мөн багаар ажиллах чадварт суралцаж, урлаг спортын авьяас чадвараа нээн хөгжүүлсэн. | 90% |
| 84 | | 2. Хөдөлмөр зусланг | 2021 - 2024 | | 3 | Богд сумд хэрэгжсэн хөдөлмөр зусланд 14 хүүхэд хамрагдсан. Хөдөлмөр зусланг байгуулснаар хүүхэд, өсвөр | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллуулах | | | | үеийнхэн Монгол ёс заншил уламжлалт арга ухаан, үнээ саах, ямаа саах, тараг бүрэх зэрэг мал аж ахуй тэр дундаа сүү цагаан идээ боловсруулах, сур элдэх, түлш түлээ, хоол хүнсээ бэлтгэх зэргээр амьдрах ухаанд суралцсан. Бусад сумдад Хөдөлмөр зусланг ажлуулах боломж хомс байгаа тул Өвгөнжаргалант зусланд зохион байгуулсан Хөдөлмөр зуслангийн ээлжинд Бөмбөгөр, Баацагаан, Бууцагаан, Заг, Эрдэнэцогт, Баян-Өндөр, Баянхонгор сумын нийт 30 хүүхэд хамрагдсан. | |
| 85 | | 3. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэн тохижуулах | 2021 - 2024 | | 40 | Хүүхдийн авьяас чадвар бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, үндэсний өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ-ын хүүхдийн сантай гэрээ байгуулж 25.0 сая төгрөгийн санхүүжилтээр хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, зуслангийн хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, Морин хуур-10, Лимбэ-2, Шанз-2, Ёочин-2, Хуучир-2, Ятга-2, Мандолин-10, Гитар-10, Гар бөмбөг-5, Сагсан бөмбөг-5, Хөл бөмбөг-3, Теннисний ширээ-2, Волойболлын тор-2, Аркет-4, Танин мэдэхүйн тоглоом-10, Монгол гэр угсардаг тоглоом-10, Номын сан байгуулах ном-180 ширхгийг тус тус шинээр авсан. Зуслангийн 5 бүлэг, 2 гал тогоо, соёлын төв, цагдаагийн байр, теннисний өрөөний дотор болон гадна талыг будаж засварлах, зусланг тойруулан хашаа хийх, 3 газарт хаалга хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. “Өвгөнжаргалант” зусланд спорт цогцолбор, урлагийн заал, хүүхдийн эко 00 хийх төсөл бичиж, зураг төсвийг ХНХЯ, ЗГХА-ГБХЗХГ-т тус бүр 2 удаа хүргүүлсэн. Тус төслийн хэрэгжилт нь хяналтын шатандаа явж байна. Аймгийн 2024 оны зуслангийн их засварын төсвийг тусгасан. Өвгөнжаргалант зуслагийн тохижилт 60 хувьтай байна. | 100% |
| 86 | 2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг | 2. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх | 2021 - 2024 | | 10 | Хүүхдийн оролцооны үндэсний чуулганд-23 хүүхэд, Монголын хүүхдийн зөвлөлийн майхант цугларалтад-9, Теен хуралдайд-2, “Өсвөрийн парламент-2023” хөтөлбөрт-4, нийт 34 хүүхдийг улсын хэмжээний хурал чуулганд оролцуулснаар хүүхэд өөрийн мэдлэгийн хүрээгээ тэлж, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | илтгэх, ярих, багаар ажиллах чадваруудад суралцаж чадавхажсан. Оролцооны байгууллагаас санаачилсан Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Илтгэлийн тэмцээн зохион байгуулж 20, Сургуулиудын хүүхдийн зөвлөл болон ХОӨУБ-уудын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж 98, “Найз байя” аян-100, Охидын өдөрлөг-110 охин, Сэтгэлийн гал-20, Мартагдашгүй март-15, “Бидний манлайлал” охидын өдрийн арга хэмжээ-25, “Movie night” кино хэлэлцүүлэг-35, Өсвөр насны сурагчдын дунд мэтгэлцээний тэмцээн-40 зэрэг 9 төрлийн арга хэмжээг дэмжин хамтран зохион байгуулж, нийт 467 хүүхэд оролцсон байна. | |
| 87 | | 3. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах | 2021 - 2024 | Хүүхэд хамгааллын зардлаас | 35 , 85 | Сумдын хамтарсан багуудыг чиг үүргээр хангаж 2 удаа зөвлөмж хүргүүлсэн. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах хүрээнд: - Баянхонгор сумын хамтарсан багийн гишүүн 50 хүнийг чадавхжуулах сургалтыг 1, Аймгийн хэмжээнд ажиллаж буй хамтарсан багийн гишүүдэд “Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга зүй”-н сургалтыг Баянхонгор аймагт 1, Орон нутгийн 19 сумын хамтарсан багийн 168 гишүүнд "Хамтарсан багийн гишүүдийн анхаарах асуудал, санхүүжүүлэх аргачлал" сургалтыг 1, “Амар тайван гэр бүл” нэгдсэн өдөрлөгийн хүрээнд хамтарсан багийн гишүүдэд арга зүй өгөх, ажлын байран дээр нь зөвлөн туслах ажлыг 1, “Гэр бүлийн хөгжил хамгаалалд хамтдаа” нэгдсэн арга хэмжээний үеэр хамтарсан багуудын өргөтгөсөн хурлыг зохион байгуулж статистик тоон мэдээлэл танилцуулах, арга зүй өгөх сургалтыг 1, Туршлага судлах өдөрлөгийг 4 бүсэд 1 удаа тус тус зохион байгуулсан. Нийт 20 сумын 30 хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, зөвлөн туслах, туршлага судлуулах ажлыг 6 удаа зохион байгуулж 373 гишүүнийг бүрэн хамруулсан байна. Эрдэнэцогт сум 5 кейс, Баянговь сум 2 кейс, Баянлиг сум 1 кейс, Жинст сум 3 кейс нийт 11 кейсийг нийгмийн ажилтны мэдээллийн санд шивж 1.445.052 төгрөгийн санхүүжилтийг авсан. Урьдчилан | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | | | | | | сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах хүрээнд Өлзийт, Баянговь, Хүрээмарал, Эрдэнэцогт, Галуут Гурванбулаг сумдад 5.632.420 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | |
| 88 | 2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна. | 1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 25 | Соёл урлагийн байгууллагуудаас соёлын баримтат өвийг бий болгох, угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 28 арга хэмжээ зохион байгуулан ажиллаж аймгийн хэмжээнд 6731 өрх угийн бичиг хөтөлдөг, шинээр 435 өрх хөтөлж эхэлсэн, угийн бичиг хөтлөх сургалтад 2388 иргэнийг хамруулж угийн бичиг хөтлөлтийг 15.7 хувиар нэмэгдүүлэн 31%-д хүргэсэн. Угийн бичиг хөтлөлтийн “Хонгор холбоо” Төрийн бус байгууллагатай хамтран Баянхонгор аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын алба хаагчдад угийн бичиг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулж суурь түвшний судалгаа гаргаж явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70% |
| 89 | 2.8.8. Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг сайжруулна. | 1. Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах | 2021 - 2024 | | 70 | Сайн дурын үзэл санааг залуучуудад төлөвшүүлэх зорилготой “Нэг хамт олон - Нэг сайн дурын ажил” нөлөөллийн аяныг өрнүүлж 35 аж ахуй нэгж, албан байгууллагын 3210 иргэн нийгэмд тустай 50 гаруй төрлийн сайн дурын ажил хийсэн. Монголын хүүхдийн спортын VII наадамд ажиллах 100 сайн дурын ажилтан, Хангайн бүсийн хүүхдийн чуулганаар ажиллах 20 сайн дурын ажилтныг бэлтгэн Сертификат олгосноор бэлтгэгдсэн сайн дурын нийт ажилтны тоо 420 болсон. Журмын хэрэгжилт 75 хувьтай байна. | 100% |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 90 | 3.1.1. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган татвар төлөгчдийг бүрэн хамруулж | 1. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд | 2021 - 2024 | | 1150 | 1.Аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн урд оны хуримтлагдсан өр, тайлант оны ногдлыг хураан барагдуулах, татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж, холбогдох хууль, журмын дагуу газрын төлбөрийн ногдол үүсгэх, төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Прокурорын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | татварын орлогын суурийг нэмэгдүүлнэ. | хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах | | | | газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэстэй хамтран 6 сарын хугацаатай “Газрын төлбөрийн урьд оны хуримтлагдсан өр, ногдлыг барагдуулах" удирдамжийг баталж, судалгаа, мэдээллийг нэгтгэсэн. Аяны хүрээнд нийт 558 сая төгрөгийн газрын төлбөрийн орлого төвлөрүүлсэн.Хуулийн этгээд, хувь хүний эзэмшилд байгаа авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийн төлөлтөд хяналт тавих, бүртгэл судалгааг тулгах, татвар төлөгчийн тээврийн хэрэгслийн өрийг барагдуулах зорилгоор аймгийн Цагдаагийн газартай хамтран "Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх" арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 01–ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулж ажиллав. АТБӨЯХ-ийн албан татвар төлөгчийн бааз суурийг шинэчлэх, үнэн бодитой тоо мэдээг бий болгох зорилгоор сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, албан татвар төлөөгүй 5639 тээврийн хэрэгслийн судалгааг сум тус бүрээр гаргаж сумдын байцаагч нарт хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд 15 суманд 1494 татвар төлөгчийн тээврийн хэрэгслийн хасагдах материалыг хүлээн авч албан татвар төлбөрийг нөхөн төлүүлж АТҮТ-ийн төвийн баазаас хасуулав. АТБӨЯХАТатвар 610000 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 676082,4 мянган төгрөг буюу 110,8 хувийн биелэлттэй. ҮХЭХөрөнгийн татвар 637400 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 593430,6 мянган төгрөг буюу 93,1 хувийн гүйцэтгэлтэй. Галт зэвсгийн албан татвар 75565 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 62288 мянган төгрөг буюу 82,4 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 91 | | 2. Газрын төлбөр ногдуулалт нэхэмжлэлийг 100% хийж дуусгах, | 2021 - 2024 | | 380 | Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т "Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны 02 дугаар сарын 10- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шугам сүлжээнээс газрын төлбөр авч татварт хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулж бааз суурийг нэмэгдүүлэх | | | | ны дотор татварын албанд хүргүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай. Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу ГХБХБГ-аас газрын бүртгэл, ногдлын мэдээлэл буюу ГХБХБГ-ын Landndmen программыг татварын удирдлагын нэгдсэн системтэй холбож 2023 онд 7961 татвар төлөгчийн 1093.6 сая төгрөгийн ногдлыг цахим төлбөрийн баримтын систем болон цахим тайлангийн системээр шууд хүргүүлж, 702.5 сая төгрөгийн өрийг бүрэн барагдуулсан. Газрын төлбөр төлөгчдийн татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх хүрээнд 0.20 мөнгөнөөс эхлээд 500000 хүртэл өртэй 5226 татвар төлөгчийн дансыг битүүмжлүүлэхээр ХААН банкинд албан бичиг хүргүүлж, үл маргах журмаар 2500 татвар төлөгчийн өрийг барагдуулж, 2726 татвар төлөгчийн дансыг битүүмжилсэн. Газрын төлбөрийн өр барагдуулалтыг эрчимжүүлэх хүрээнд Баянхонгор аймгийн Прокурорын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс хамтран 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл 6 сарын хугацаатай "Газрын төлбөрийн урьд оны өр, ногдлыг барагдуулах чиглэлээр хийгдэх хамтарсан ажлын удирдамж"-ийг баталж, газрын төлбөрийн барагдуулалтыг аймгийн хэмжээнд эрчимжүүлж ажилласан. 2023 оны газрын төлбөр орлогын дүн 746935,9 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 761961,6 мянган төгрөг буюу 102 хувийн биелэлттэй байна | |
| 92 | 3.1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг сумдад зохион байгуулна. | 1. Эрсдэл өндөртэй төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт, үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | | 9 | 2023 онд сумдын төсөвт 81 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл өндөртэй үнэлэгдсэн 4 сумын 24 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар баталсан. Үнэлгээний үр дүнгээр эрсдэл өндөртэй Заг, Гурванбулаг, Галуут, Хүрээмарал сумдын санхүүгийн үйл ажиллагаанд Засаг даргын нэрэмжит санхүүгийн хяналт шалгалт, санхүүгийн үзлэгийг зохион байгуулж нийт 468,263,786 төгрөгийн зөрчил илрүүлж 104,503,929 төгрөгийн албан шаардлага хүргүүлж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 35,580,514 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 328,179,343 төгрөгийн зөвлөмж өгч, санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг 25 хувиар бууруулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан. Эрсдэл өндөртэй 4 сумын 24 байгууллагад санхүүгийн нэгдсэн хяналт шалгалт, үзлэгийг зохион байгуулж эрсдэлтэй байгууллагын тоог 33 болгож бууруулан төсвийн үр ашгийг 35,580,514 төгрөгөөр нэмэгдүүлсэн. | |
| 93 | | 2. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг байгууллага тус бүр дээр хэлэлцүүлж, залруулах арга хэмжээ авах | 2021 - 2024 | | 3 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар шууд захирагчийн 11 байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 6 байгууллага Хязгаарлалттай дүгнэлт авсан, Үүнээс Баянцагаан ЗДТГ, Богд ЗДТГ, Жаргалант ЗДТГ, Баян-Өндөр ЗДТГ, Бөмбөгөр ЗДТГ, Баян-овоо ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга нартай чиглэл өгч аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг сум бүрээр хэлэлцэн цаашид гаргахгүй, залруулах арга хэмжээг хэмжээг хэлэлцсэн. | 0% |
| 94 | 3.1.3. Хуримтлалтай хонгорчууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Хуримтлалын бүлгийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 138 | Баянхонгор аймгийн Монгол банкны салбарын мэдээгээр 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдөр нийт 67083 хадгаламж эзэмшигчдийн дансанд 134,6 тэрбум төгрөгийн хадгаламж байршиж байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн мэдээгээр нийт 65536 хадгаламж эзэмшигчдийн дансанд 147.2 тэрбум төгрөг байршиж байгаа бөгөөд урьд оноос 10,9 хувиар буюу 12.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 10 сумын 110 бүлэг зохион байгуулалтад орж үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байна. | 90% |
| 95 | | 2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох | 2021 - 2024 | | 6 | 2023 оны жилийн эцсийн байдлаар "Дэлхийн мөнгөний долоо хоног" аяны хүрээнд Мөнгөний үүсэл хөгжил, үнэ цэнэ, санхүүгээ зөв төлөвлөж, ирээдүйдээ хуримтлал үүсгэхийн ач холбогдол, хувь хүний санхүү , “Санхүүгээ зөв төлөвлөж, ирээдүйгээ бүтээцгээе” сэдэвт санхүүгийн боловсрол олгох сургалтуудыг аймгийн төвийн болон | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бууцагаан сумын ерөнхий боловсролын сургуулиудын нийт 6620 сурагчдад хийж, гарын авлага, эвхмэл брошур, санхүүгийн боловсролын видео шторкуудыг нэвтрүүлэн ажиллалаа. Мөн түүнчлэн "Жижиг мөнгөн тэмдэгтийг хэн сайн цуглуулах вэ" уралдааныг хүүхдүүдийн дунд 8 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж 1-т, 5-т, 10-т, 20-тийн дэвсгэртийг нийт 73 хүүхэд 65331 ширхэг дэвсгэрт цуглуулан, мөнгөө арилжааны банканд өгч сайн тэмдэгтээр солиулж авлаа. Хамгийн олон дэвсгэрт цуглуулсан эхний 3 хүүхдэд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр шагналыг нь гардуулан өгсөн. Хүүхдүүдийг мөнгөн тэмдэгт зөв боловсон харьцах, цуглуулж хуримтлуулах дадал хэвшилд сургасан. Тайлант онд нийт 3 ажил арга хэмжээг зохион байгуулж 6753 хүүхдийг хамруулсан. | |
| 96 | 3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. “Жишиг санхүүгийн алба” үзүүлэх сургалт” зохион байгуулах | 2021 - 2024 | Байгууллагын зардал | 14 | Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн цахим шилжилтийн бодлого, зорилтын хүрээнд улс орон даяар 2023 оноос эхлэн төрийн сангийн нэгжүүдээр хийгдэх төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог "Төрийн сангийн удирдлагын цахим систем" буюу шинэ цахим системд бүрэн шилжүүлсэн. Сумдын санхүүгийн албаны төлбөр тооцоо шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор 2023 онд "Жишиг санхүүгийн алба" үзүүлэх сургуулийг сумдад зохион байгуулаагүй бөгөөд аймгийн төрийн сан дээр шинэ төлбөр тооцооны системийн сургалт, зөвлөгөө, дадлага ажлыг 2023 оны 5 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд хийсэн. Төрийн сангийн төлбөр тооцооны цахим шинэчлэл ажлын хүрээнд сумдын санхүүгийн албадын дунд "Шилдэг цахим санхүүгийн алба уралдааныг аймгийн Засаг даргын 2023 оны А/31 дүгээр захирамжаар батлуулан, амжилттай зохион байгуулсан. | 100% |
| 97 | | 2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, | 2021 - 2024 | | 83 | 2023 оны эхний хагас жилийн тайлангаар Том аж ахуйн нэгж байгууллага ангилалд хамаарагдах 72 аж ахуйн нэгж байгууллага тайлангийн шинэ системээр тайлангаа илгээж ирц 100 хувьтай байна. 2023 оны жилийн эцсийн тайлан 2024 оны 02 сарын 15-наар тасалбар болж 03 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх | | | | 01-нд гарна хүлээгдэж байна. | |
| 98 | | 3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 53 | Нягтлан бодох бүртгэлийн аймгийн үзлэгийн хүрээнд Жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагуудад Сангийн яамны зөвшөөрөлтэй ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг ашиглахыг зөвлөв. | 30% |
| 99 | 3.1.5. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулна. | 1. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгах | 2021 - 2024 | | 3 | Орон нутгийн өмчит эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогод орон нутгийн өмчит 173 байгууллагын 740 ширхэг 10,8 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгслээс 650 тээврийн хэрэгсэл зөчилгүй, 90 тээврийн хэрэгсэл зөрчилтэй бөгөөд үүнээс тээврийн хэрэгсэл улсын дугаар авах шаардлагатай 25, тээврийн хэрэгслийн авто тээврийн нэгдсэн сангаас хасалт хийлгэх шаардлагатай 65 тээврийн хэрэгсэл байсан. Зөрчлийг арилган ажиллах талаар албан тоотыг холбогдох 90 байгууллагад хүргүүлснээс 31 тээврийн хэрэгслийг авто тээврийн нэгдсэн сангаас хасуулж, 18 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг олгуулан зөрчлийг арилгасан. Холбогдох байгууллагууд тээврийн хэрэгслийн улсын дугаарыг авахад шаардлагатай гаалийн бичгийг үрэгдүүлсэн гэх мэт шалтгааны улмаас зөрчил бүрэн арилаагүй байна. Мөн маргаантай 2 тээврийн хэрэгслийн 1 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан балансаас балансад шилжүүлэхээр Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 04 өдрийн хурлаар оруулсан. Хурлын тогтоол гараагүй байна. Дутагдуулсан Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 ширхэг гинжит тракторыг хуулийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд шийдвэр гараагүй шалгагдаж байна. 2023 онд 68 автомашин шинээр авснаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 50 авто машины зөрчлийг арилгуулж буурсан зөрчлийн хувь- 45,5 | 50% |
| 100 | | 2. Бүртгэлээр тавих | 2021 - | | 15 | Аймгийн ИТХ-ын Хуралдааны тогтоолоор 38,752 сая төгрөг, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, коджуулах | 2024 | | | ИТХ-ын даргын захирамжаар 14,948 сая төгрөг, нийт 29,700 сая төгрөгийн хөрөнгөтэй холбоотой шийдвэр гарч, данс бүртгэлд тусгуулж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргасан. Мөн илүүдэлтэй, ашиглалтгүй 2 барилга, байгууламжийг уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилж орон нутгийн төсөвт 241,7 сая төгрөг төвлөрүүлсэн. Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 68 дугаар захирамжаар 20 сумдын эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг давуу эрхтэйгээр хувьчлах тогтоол гарч 113,2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх тухай удирдамжийн дагуу 153 байгууллагын гэрээг дүгнэх ажилтай хамтатган хөрөнгийг коджуулах, хөрөнгийн бүртгэл хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж өгсөн."Үйлдвэржилт хөгжлийн корпораци", болон Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгт хяналтын тооллого хийж тооллогоор үндсэн хөрөнгүүдийг коджуулаагүй, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгээгүй зэрэг зөрчилтэй гарсан тул зөрчлийг арилгаж ажиллах тухай хугацаатай албан бичиг хүргүүлсэн. Төсвийн байгууллагын шинээр томилогдсон нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалтаар дагаж мөрдөх хууль тогтоомж, журмыг сурталчилан таниулж, байгууллагад ашиглагдаж буй эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийн коджуулалтыг чанаржуулах талаар зөвлөмж өгсөн. "Гүүр софт" ХХК-ний гаргасан хөрөнгийн бүртгэлийн цахим программыг ашиглан 2022 онд орон нутгийн өмчит 4 байгууллагын үндсэн хөрөнгүүдийг QR коджуулан хөрөнгийг зургаар баталгаажуулан ажилласан. Тус программыг цаашид ашиглахад QR код дахин хэвлэлтэд оруулах боломжгүй, тус программыг хөгжүүлэх шаардлагатай байгаа тул ажлыг хойшлуулсан. | |
| 101 | 3.2.1. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад | 1. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, | 2021 - 2024 | Төсөл хөтөлбөрийн зардал 62 сая | 1 | Аймгийн хэмжээнд Щвейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь, НҮБ-ын Хүүхдийн Сангийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | харилцааг идэвхижүүлж оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх санал хүргүүлэх, уулзалт зохион байгуулах | | төгрөг | | санхүүжилтээр “Утаагүй Баянхонгор”, НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ”, Франц улсын санхүүжилтээр Тогтвортой ноолуур, Европын Холбооны санхүүжилтээр Бүгд Залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө, Best хөтөлбөр, Дэлхийн банкны санхүүжилтээр Тогтвортой Амьжиргаа-3, Монголын Улаан Загалмайн нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Хүүхэд эсэн мэнд амьдрахуй” төслүүдийг хэрэгжүүллээ. Энэ онд шинээр “Малчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь” 62 сая төгрөгийн санхүүжилттэй төслийг аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, 20 сумдын Эрүүл мэндийн төвүүд хамтран хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт малчдын 40 түгнээс дээш хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөсөн. Үзлэгийг зохион байгуулж, малчдын 41.7 хувийг үзлэг оношилгоонд хамруулсан. Малчдын эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөөнд 12 ажил арга хэмжээг тусган, хэрэгжүүлснээр хэрэгжилт 90 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан 5682 малчнаас 1147 хүн эрүүл мэндийн эрсдэлтэй гэж оношлогдсон бол дараагийн шатлалын лавлагаа, төрөлжсөн эмнэлэгт нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай малчин 633, стационарт онош тодруулах, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай малчин 511, сувилалд эмчлүүлэх шаардлагатай малчин 540 байна. Дээрх эрүүл мэндийн эрсдэлт бүлэгт харьяалагдаж байгаа 1147 малчин, онош тодруулах шаардлагатай 633 малчныг илрүүлсэн нь үзлэг оношилгооны үр дүн юм.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд цаашид хэвтүүлэн эмчлэх шаардлагатай дээрх 511 малчдыг системтэйгээр хэвтүүлэн эмлэж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. | |
| 102 | 3.3.1. Орон нутагт уул уурхайн | 1. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж | 2021 - 2024 | | 70 | “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | буй ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг хангуулах | | | | байр нэмэгдүүлэх" тухай 8 гэрээг байгуулсан. Өмнөх онд байгуулсан гэрээний биелэлтийг дунджаар 95 хувьтай дүгнэсэн. | |
| 103 | 3.3.2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна. | 1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 8 | "Хариуцлагатай уул уурхай" сургалтыг уул уурхай бүхий Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут нийт 7 сумын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар "Эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрөөс баримталж буй бодлого", "Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт", "Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс 2021-2022 онд төвлөрсөн хандив дэмжлэг", "Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй арга хэмжээ", "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам", "Уул уурхай дахь байгаль орчны салбарын бодлого" зэрэг нийт 6 сэдвээр сумын 200 гаруй иргэдэд мэдлэг олгосон. | 100% |
| 104 | 3.3.3. "Баялагийн сан" байгуулж, олон нийтийн хяналтан дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | 1. Баялагын сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгооор хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 20 | "Баянхонгор сан"-г байгуулж, сан бүрдүүлэх захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/07 дугаар тогтоолоор баталсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам руу хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуух хандив дэмжлэг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөхөөр хуульчилсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 10,644.6 сая төгрөгийн 94 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 105 | 3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2021 - 2024 | | 25 | "Хариуцлагатай уул уурхай" сургалтыг Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут сумдын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад сумдын удирдлага бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн гишүүд, иргэд хамрагдсан ба сургалтаар Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Төрийн хяналт шалгалт, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Байгаль орчин гэсэн 4 төрлийн мэдлэгийг олгосон. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2021 онд 43, 2022 онд 17, 2023 онд 12 болон буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100% |
| 106 | | 2. Бичил уурхай эрхлэгчдийг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, хяналт тавих | 2021 - 2023 | | 2 | Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журам батлагдаж бичил уурхай эрхлэгчид хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон. Журмын дагуу энэ онд Бууцагаан суманд 1, Бөмбөгөр суманд 3, Галуут суманд 1 бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарч 4 талбайд нөхөрлөл гэрээ байгуулсан. Хууль бусаар ашигт малтмал эрэн хайсан 164 хэргийг бүртгэж, 139 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 19 зөрчлийг зөрчлийн шинжгүй гэж үзэн татгалзаж, харьяаллын дагуу 6 зөрчлийн хэрэг шилжүүлж шийдвэрлэсэн. Торгууль, шийтгэврийн биелэлт 100% байна. | 100% |
| 107 | 3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | 1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 | Засаг даргын нөөц хөрөнгө 16,0 сая төгрөг, Уул уурхайн аж ахуй нэгжийн хөрөнгө 150,0 сая төгрөг | 15 | Эвдэрсэн газрын 2021 оны тооллогоор аймгийн хэмжээнд нийт 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 21 багийн 120 нэгж талбарт 586,74 га талбай эвдрэлд орсон байсан. Аймгийн Засаг даргын 2023 оны “Эвдэрсэн газрын хяналтын тооллого зохион байгуулах тухай” А/317 дугаар захирамжийн дагуу хяналтын тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 10-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 17 сумын 224 нэгж талбарт 729,4 га эвдрэлд орсон байна. Үүнээс 2021-2022 онд 174,4 га, 2023 онд 43,98 га талбайд нийт 218,38 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буюу нийт эвдэрч орхигдсон талбайн 30 хувьд нь техникийн нөхөн сэргээлтийг хийсэн үр дүнтэй төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна | |
| 108 | 3.4.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгоно. | 1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | 2021 - 2024 | Улсын төсөв | 70 | Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан “Базарь дарь” ХХК шалгаран барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Тоног төхөөрөмжийг БНХАУ-аас татан авч угсралтын ажил 80%-тай явагдаж байна. Тус үйлдвэрийн үйл ажиллагааг "Ингэн Эрдэнэ" ОНӨААТҮГазар байгуулагдан хариуцан ажиллаж байна. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум бөгөөд санхүүжилтийг бүрэн олгосон. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Сант-Өндөр" ХХК шалгарч барилгын ажлыг 2021 онд эхлүүлсэн ба 2024 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 100% |
| 109 | 3.4.2. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 1. Хөдөө аж ахуйн загвар хоршоо байгуулах | 2022 - 2024 | | 1 | Хоршоог дэмжих хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 90 дүгээр тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III” дэд хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь 2020-2024 он хүртэл хэрэгжих юм. Хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 97.04 хувь байна. Хоршоотой холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түгээх, сурталчлах талаар аймгийн хоршоологчдын зөвлөгөөнийг ХХААХҮЯ, Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоотой хамтран 2023 оны 1 сард зохион байгуулж орон нутгийн удирдлага, хоршоодын 120 гаруй төлөөлөлтэйгээр зохион байгуулсан. Мөн "Хоршоодын шинэчлэл-хөгжлийн шинэ эхлэл” хөдөө аж | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн Дундговь аймаг, Гурвансайхан сумд 7 сард зохион байгуулагдсан.бөгөөд тус аймгаас 4 хоршооны 8 төлөөллийг оролцуулж туршлага судлуулсан. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 13 сум 53 иргэн, хоршоодод 1.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, ажлын байр нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. | |
| 110 | 3.5.1. “Бизнес инкубатор”-ийн бодлогыг эрчимжүүлж, гарааны бизнесийг дэмжиж бойжуулна. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, бойжуулах | 2022 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 30 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2023 онд тус аймгаас журмын дагуу шаардлага хангасан 10 ААН 1.153 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 34 ажлын байр шинээр бий болгосон. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 2017 оноос хойш төсөв батлуулан дэмжиж ажиллаж байгаа бөгөөд энэ онд 47 иргэн, ААН-д 652.0 сая төгрөгийн зээл олгож, 73 ажлын байрыг бий болгов. Зээлийн нийт эргэн төлөлт, хүүгийн эргэлт тус санд 2 тэрбум байна. Орон нутагт хэрэгжиж буй олон улсын BEST хөтөлбөрөөс 4 иргэн, ААН-д 34.4 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож хамтарч ажиллаж байна. Сумдад хэрэгжиж буй “Хоршоог хөгжүүлэх сан”-аас 13 сумын 47 иргэн, ААН 1.1 тэрбум төгрөгийн зээл авч, хуучин 49 ажлын байрыг хадгалж, шинээр 40 ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. Тайлант онд нийт 3137 иргэн, аж ахуй нэгжид 2.939.4 тэр бум төгрөгийн санхүүжилт олгож, 1898 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн. | 70% |
| 111 | 3.5.2. Хүн амын хүнсний хэрэгцээний нөөцийн махыг хувийн хэвшлүүдээр бэлдүүлж дэмжлэг олгоно. | 1. Махны нөөцийг бүрдүүлж, үнийг тогтворжуулах | 2021 - 2024 | | 200 | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг хانган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг "Баянхонгор констракшн" ХХК-д олгосон. | |
| 112 | 3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ. | 1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Улсын төсөв | 70 | Манай аймаг хонин сүргийг Баянбулаг хониор, ямаан сүргийг Бөмбөгөрийн улаан омог, Залаажинст-Эдрэн үүлдрээр сайжруулах, Тэмээн сүргийг Ламын гэгээний улаан тэмээ үржлийн хэсгээр, адуу, үхрийг өөр дотор нь сонгон үржүүлэх бодлого барьж ажиллаж байна. Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор монгол оронд дасан зохицсон баталгаажсан Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авч цөм сүргийн нэгжийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын харьяанд бий болгосон. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар хэрэгжүүлж байгаа Малын чанар сайжруулах ’’ Шинэ хөдөө’’ төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг омгийн өсвөр хээлтүүлэгч-500, хээлтэгч-400, Сэлэнгэ үүлдрийн Бухан бяруу-20 үржлийн хээлтэгч -43, Сарлагийн бухан бяруу-6 хонь, үхрийн ашиг шим, чанарт анхаарч цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор үржлийн малыг худалдан авч сумдад хүлээлгэн өгсөн.Улсын төсвийн 8,5 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхонгор, Баянговь, Баян-Овоо, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Эрдэнэцогт зэрэг 10 сумын 5667 бог малд, мөн Баянбулаг, Баян-Өндөр, Богд, Жинст, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст зэрэг 7 сумын 5521 бог малын хээлтүүлэгчийн үзлэг ангилалтын ажлыг тухайн сумын хүний нөөцийн тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр Гурванбулаг, Галуут, Өлзийт, Эрдэнэцогт сумын 1780 сарлагт, Баянлиг сумын 859 тэмээнд, Баянбулаг, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст сумын 4937 хонинд, Баянбулаг, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст, Баян-Өндөр сумын 2686 ямаанд нийт 10262 толгой малыг үзлэг ангилалтад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан. Бусад сумдууд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 306 малд үзлэг ангилалт хийсэн. Энэ онд нийт 31.7 мянган малд үзлэг ангилалт хийж, өмнөх оныхоос 6.8 мянга буюу 27.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 113 | | 2. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтад ялган төвлөрүүлэх | 2021 - 2024 | | 70 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр 10262 толгой малыг, улсын төсвийн 8,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11188 толгой хээлтүүлэгчийн ангилалтын ажлыг зохион байгуулсан. Мөн Шинэ хөдөө төслийн хүрээнд баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүүлэгч худалдан авах ажлыг зохион байгуулж 20 сумын 57 багийн 62 суурьт Баянбулаг омгийн өсвөр хуц 5766 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн өсвөр ухна 8171 толгойг ялган төвлөрүүлсэн, хээлтүүлэгчийн хувь 79,4 хувьтай байна | 100% |
| 114 | | 3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | 2022 - 2024 | Орон нутгийн төсөв | 100 | НҮБ-тай хамтран нийт 13 сумын 390 малчин өрхөд ядарч доройтсон малыг хэрхэн тэнхрүүлэх, бэлчээрийг хэрхэн зүй зохистой ашиглах, малыг хэрхэн тэжээх зэрэг сэдвээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн улс, аймгийн хэмжээнд анх удаа 20 сумын 105 багийн мянган малчныг хамруулж "Эрдэнэт сүргийн эзэд-1000" малчдын чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж урлаг, спортын төрлөөр нөхөрсөг тэмцээн амжилттай зохион байгууллаа. Чуулганы үеэр урлагийн 11 төрөл, спортын 7 төрлөөр урлаг, спортын наадмыг амжилттай зохион байгуулж, оролцогчдын ур чадвар, оролцооны байдал, сахилга хариуцлагыг харгалзан дүнг нэгтэн шилдгүүдийг тодруулаа. Шилдгийн шилдэг сумаар Баянлиг сум шалгарч 20,0 сая₮, хоёрдугаар байранд Бууцагаан сум шалгарч - 15,0 сая₮, гуравдугаар байранд Бөмбөгөр сум шалгарч – 10,0 сая₮, дөрөвдүгээр байранд Баянговь сум шалгарч – 5,0 сая₮, тавдугаар байранд Хүрээмарал сум шалгарч – 5,0 сая₮-ийг тус тус гардан авлаа. Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хуралтай хамтарч "Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээний үеэр 20 сумын 10,000 гаруй малчдад цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амжилттай зохион байгууллаа. | |
| 115 | 3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана. | 1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв | 2 | 2023 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын А/202 тоот захирамжийн хүрээнд хэрэгжүүлж орон нутагт зонхилон гардаг мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 нэр төрлийн дархлаажуулалтад 1,6 сая толгой мал хамруулах төлөвлөгөөтэйгөөс 12 сарын байдлаар 98,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрхи арга хэмжээг оновчтой төлөвлөн хэрэгжүүлснээр мал амьтны халдварт өвчний гаралт өмнөх оныхоос 53 хувиар буурсан үзүүлэлттэй байна.Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнөөр тайван бүсээ хадгалан ажиллаж байна. Шүлхий өвчний хавар, намрын дархлаажуулалтад 20 сумын 105 багийн 211129 мэдрэмтгий мал, амьтныг нэгдсэн системд төлөвлөж 6337 өрхийн Үхэр- 237751, гахай-171 нийт- 237922 толгой мал, амьтныг хамруулан 100% гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд 17 сумын 92 багийн түвшинд 29656 /Тэмээ-26, Адуу- 1690, Үхэр- 5287, Хонь-10025, Ямаа- 12628 /мал, амьтан зүй бусаар хорогдсон байна. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын сэг, зэм устгалын ажлыг зохион байгуулж, ажлын хэсэгт 92 автомашин 1143 хүн хүч ажиллаж нийт-25334 /Тэмээ-17, Адуу- 1246, Үхэр- 4704, Хонь-8676, Ямаа- 10395, Амьтан-296/ мал, амьтны сэг зэм устгалын арга хэмжээг зохион байгууллаа. Сэг зэмийн орчимд нийт- 431707 м2 / Хашаа хороо, өтөг бууц, бэлчээрийн талбай, Нийтийн эзэмшлийн талбай, худаг, уст цэг, Агуулах, зоорь, түүхий эд агуулах, Устгалын цэг/ талбайд халдваргүйтгэлийг хийсэн. | 100% |
| 116 | | 2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын | 2021 - 2024 | | 7000 | Мал эмнэлгийн нэгдсэн системийн хүний нөөцийн удирдлагын системд 51-н Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, Мал эмнэлгийн газрын 43-н алба хаагч, 1 махны үйлдвэрүүдийг холбож үйл ажиллагааг системээр хянан баталгаажуулж байна. Тайлант онд нийт 8811-н удаагийн гэрчилгээ, гарал үүсэл бичигдсэн. Задалбал амьтан хэрэгцээлэх зориулалтаар 2364, бүтээгдэхүүнээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих | | | | 5607, отор нүүдэл 326, үржилийн зориулалтаар 514-н гэрчилгээ тус тус бичигдсэн. Адууны мах 604, тэмээний мах 157, хонины мах 2009, ямааны мах 1669, үхрийн мах 2201-н гэрчилгээ тус тус зах зээлд нийлүүлэгдсэн байна. | |
| 117 | | 3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв | 15 | Аймгийн хэмжээнд халдвар хамгааллын иж бүрэн хувцас 800 ширхэг, нүдний шил 800ш, маск 800ш, хормогч 800ш, улавч 800ш, халдваргүйтгэлийн бодис болох Hi-cop 600кг, Han-con 250кг, гипохлорт кальци 200кг, супер килл 20кг, спирт76 градус 10л, спирт 96 градус 80л тус тус байна. 20 сумын хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, Мал эмнэлгийн тасгууд тодорхой түвшинд гамшгийн эрсдэлээс хамгаалах нөөц бүрдүүлж, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэж ажилласан байна. Аймгийн мал эмнэлгийн газарт халдвартгүйтгэлийн дук авто машин 2 ширхэг байна. | 100% |
| 118 | 3.6.3. Бэлчээр менежментийг сайжруулах зорилгоор шаардлагатай цэгүүдэд уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна. | 1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв | 5 | Улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баацагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өрмийн худаг шинээр гаргах буюу сэргээн засварласан. Нийт 8 худаг ашиглалтад орж 12,0 мянган га бэлчээр усжуулагдаж, 16,0 мянган мал усаар хангагдлаа. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Богд сум 5 цэгт, Шинэжинст сум 2 цэгт нийт 7 цэгт ус цэгийн хайгуул хийгдсэн байна. | 100% |
| 119 | | 2. Аймгийн хэмжээнд дэвшилтэт аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх | 2021 - 2024 | Улсын болон орон нутгийн төсөв | 20 | Улсын төсвийн 188.0 сая төгрөгөөр 18 сумын 43.3 мян га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Аймаг, сумын орон нутгийн төсвийн 93 сая төгрөгийн хөрөнгөөр 4,9 мянган га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулсан. Дээрх хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 92.3 хувийн үр дүнтэйгээр Улсын байцаагчийн дүгнэлт гарсан. | 100% |
| 120 | 3.6.4. Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих | 1. Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг зохих түвшинд бэлтгэх | 2021 - 2024 | | 200 , 50 | Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолоор бэлтгэж сум бүрд 30 тн өвс, 30 тн тэжээл, аймаг 200 тн өвс, 100 тн тэжээл бэлтгэхээс сумын нөөцөд 825.4 тн өвс, 43.2 тн ногоон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түвшинд бэлтгэнэ. | | | | | тэжээл, 420.9 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн. Аймагт 500 тн өвс, 36,6 тн хивэг нөөцөлсөн. | |
| 121 | 3.6.5. Техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг өсгөнө. | 1. Стандартын шаардлага хангасан 1000тн-ы төмс, хүнсний ногоо, махны зоорьтой болох | 2021 - 2023 | Улсын төсвийн 12.0 тэрбум төгрөг | 100 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд (Багц-3) Мах, ногооны 1000 тн-ийн зоорины барилгын ажлын бүрэн дуусаж ашиглалтад оруулахад бэлэн болсон. Энэ оны ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. | 100% |
| 122 | | 2. Тариалалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, дундын үйлчилгээний нэгж байгуулах | 2022 - 2024 | Улсын төсөв 630 сая төгрөг | 70 | Аймгийн хэмжээнд газар тариаланд ашиглагдаж буй техникийн судалгааг жил бүр шинэчлэн хийж байна. Хүнс хөдөө аж ахуйн газар, Баянхонгор Политехникийн коллеж, Өлзийт ХААМСҮТ, сум дундын ойн анги болон Баян-өсөх агро ОНӨАТҮГ-ийн техникүүд тариаланчдад түрээсээр үйлчлэхэд зуучлан холбож өгснөөр хаврын тариалалт, хөрс боловсруулалт, хагалгаа, төмс үрслэгээний ажлыг механикаар гүйцэтгэсэн. Энэ онд шинээр 1. Сум дундын ойн анги 130 морины хүчин чадалтай 2 трактор хадлангийн иж бүрэн 1 тоног төхөөрөмж 2. Баян-өсөхагро ОНӨАТҮГ 130 морины хүчтэй 2 трактор хүнсний ногооны иж бүрдэл 1, үр тарианы үрлэгч 1 3. Баянхонгор Политехникийн коллеж 110 морины хүчтэй 1 трактор 4. Жимсний плантацийн төвд 50 морины хүчтэй 1 трактор, 3 агрегат 5. ХХААГазар шинэ хөдөө төслийн хүрээнд 2 ширхэг төмс хураагч дүүжин машин тус тус шинээр авч ашиглаж байна. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай. | 100% |
| 123 | | 3. Хүнсний нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвөл, зуны хүлэмжийн парк аж ахуй бий болгох | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв | 25 , 0 | Хүлэмжийн нэгдсэн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж "Нарлаг хүлэмж" ХХК-тай хамтран ажилласны үр дүнд 2 аж ахуйн нэгж, 13 иргэн нийт 18.0 сая төгрөгийн 15 хүлэмжийг өөрсдийн хөрөнгөөр худалдан авч ашигласан. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмж, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлэн 100 хүлэмжийн агропаркийг байгуулах ажил амжилттай хэрэгжсэн. Нийт 6060 м,кв талбайд 50 иргэн тариалалт хийж 2.7 тн ургац | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хураан авсан үр дүнтэй байна. Улсын төсвийн санхүүжилтээр 4000 мкв талбай бүхий 7, ЖДҮ-ийн сангаас 560 м.кв талбай бүхий 4, Хятадын хамтын ажиллагааны хүрээнд 1000 м/кв 2, иргэн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр 525 м/кв 3 нийт 6000 м/кв талбай бүхий 16 ширхэг 3 улирлын нарлаг хүлэмж барьж байгуулах ажил хийгдэж байна. Үүнээс энэ онд 2525 м/кв талбай бүхий 5 хүлэмж нь ашиглалтад орж тариалалтын туршилтаа эхлүүлэх боломжтой болсон байна. | |
| 124 | 3.7.1. Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 1. Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 2021 - 2024 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжлүүлэх арга хэмжээний зардал 87,0 сая төгрөг | 5 , 6000 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Баянхонгор аймагт 2023 онд дараах томоохон ажлын хийж хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Тэмээ тэнгэрийн амьтан" тэмээний баяр, "Түйн голын жавар-2023" өвлийн наадмыг тус тус зохион байгуулж нийт 5000 гаруй дотоодын аялагч оролцсон. Монгол улсын хэмжээнд Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээ болох "Монгол туургатны харвуул их наадам"-ыг Заг-Байдрагийн хүрэн бэлчирт 07 дугаар сарын 19, 20, 21-нд амжилттай зохин байгуулж, ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, 21 аймгаас оролцохоор ирсэн харваачид, тухайн орон нутгийн малчид, төлөөлөгчид, , ЖДҮ эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэг нийт давхардсан тоогоор 7000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид 120.0 гаруй сая төгрөгийг орлого олсон. Аймгийн хэмжээнд нийт 3 томоохон эвент зохион байгуулж 12,000 мянган жуулчид оролцсон. Мөн тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр адал явдалт унадаг дугуйн аялал, Морин аялал, хадны сүг зураг сонирхох аяллуудыг зохион байгуулж салбарын контент аяллын шинэ, хөтөлбөр маршрутыг гаргаж гадаад зах зээл дээр гаргахад бэлэн болсон. Зочлох үйлчилгээний салбарын тогооч нарын "Өнгүүр буурч 2023" ур чадварын тэмцээнийг Баянхонгор хотод 2023 оны 05 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд, Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний салбарын удирдлага, менежер, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний ажилчдыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 06 сарын 05, 06-нд тус тус зохион байгууллаа. Жил бүрийн 10 сард зохион байгуулагддаг Монголын аялал жуулчлалын салбарын томоохон арга хэмжээ “Ай Ти Эм-2023” аялал жуулчлалын үзэсгэлэн Хонгор нутгаа төлөөлж аймгийн зочид буудал, жуулчны баазуудыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж оролцсон. | |
| 125 | | 2. Аялал жуулчлалын видео контент нэвтрүүлэг бэлтгэх | 2021 - 2023 | | 15 , 150000 | Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Үзэсгэлэнт Баянхонгор-2” төсөл хэрэгжүүлэх тухай А/199 дүгээр захирамжийн дагуу аймгийн түүх соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар, ахуй амьдрал, нийгэм эдийн засаг, спорт, боловсрол, урлаг соёл, ан амьтдыг илэрхийлсэн багц видео-5, Аяллын цуврал нэвтрүүлэг-3, Сумдын онцлог, байгаль, ан амьтан, хууч домог, яриа, тоглоом наадгай, үндэсний уламжлалт эдлэл хэрэглэл хийх өв соёлыг илэрхийлсэн нэвтрүүлэг 10-ыг тус тус бэлтгэсэн. Тус видео контентуудыг "Нээлттэй засаг-Нэг Баянхонгор", "Үзэсгэлэн Баянхонгор" пэйж хуудсуудаар дамжуулан иргэдэд сурталчилсан төдийгүй Аймаг байгуулагдсаны түүхт 80,81 жилийн ойн арга хэмжээгээр иргэд, олон нийт, зочид төлөөлөгчдөд аймгийг бүрэн сурталчилсан. | 70% |
| 126 | | 3. Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тохижилтийг үе шаттайгаар хийж гүйцэтгэх | 2021 - 2024 | Улсын төсөв 100,0 сая төгрөг | 1 | Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг тохижуулах ажлын хүрээнд 2021 онд Цагаан агуй, Бичигт хад, Галуут сумын Өргөөтийн рашаанд тохижилтын ажил хийгдсэн ба 2022 онд Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрхныг түшиглэн аялал жуулчлалын нийт 3 газрыг байгуулсан. Энэ онд Азийн хөгжлийн банк, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” төслөөс зохион байгуулсан бичил төсөл сонгон шалгаруулах уралдаанд Их богд хайрхны тохижилт болон Хүрэн бэлчир орчмыг тохижуулах төслөөр оролцон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгарч, тохижилтын ажлыг эхлүүлээд байна. | |
| 127 | 3.8.1. Аймгийн төв доторх шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам, явган зам, унадаг дугуйн зам барих, нөхөх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол, тэмдэг тэмдэглэгээ хийж автозамын аюулгүй байдлыг хангана. | 1. Шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам шинээр барих, нөхөөс хийх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол хийх | 2021 - 2023 | Замын сангийн хөрөнгө | 0.2, 1000м, 2 | 2021 онд аймгийн замын сангийн 46,0 сая төгрөгийн хөрөнгөөр 880 м2 хатуу хучилттай автозамын нөхөөс, 514,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Есөн эрдэнэ” захын баруун талаас Хонгор хотхоны ар тал хүртэлх 1.2 км замын барилгын ажил, түүнчлэн Эрдэнэцогт- Баянхонгор чиглэлийн 1,7км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг тус тус гүйцэтгэсэн. Мөн Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсвийг хийлгэсэн. 2022 онд 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тухайн онд 1.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 15 төсөл арга хэмжээг бүрэн хийж гүйцэтгэсэн. Тухайлбал 1,2 км зам дагуу явган хүний зам, аймгийн төв доторх 1800м2 талбайн нөхөөс, аймгийн төв доторх 1,65 км авто зам, 55 машины авто зогсоол, сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах, аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах, аймгийн төв доторх асфальтан хучилттай 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тайлант онд аймгийн төв доторх эвдэрсэн зам талбайд замын нөхөөс хийх ажлыг Баянхонгор сум руу эрх шилжүүлж тендэр сонгон шалгаруулалтыг зарлан "Их богд зам" ХХК шалгарч Замын сангийн 80,0 сая төгрөгөөр 1500м2 эвдэрсэн зам талбайд нөхөөсний ажлыг хийж гүйцэтгэсэн . Эрдэнэмандал хайрхны өвөрт авто зогсоол байгуулах ажлыг ОНХ Сангийн 70,0 сая төгрөгөөр “Унага трейд“ ХХК хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 128 | | 2. Аймгийн төв доторх хатуу хучилттай зам дагуу явган зам, унадаг дугуйн зам барих, шинэчлэх | 2021 - 2023 | Улсын төсөв | 1.2 ,0.0 | 2021 онд 600м талбайд унадаг дугуйн зам, 2022 онд нийт 4200 м2 явган зам, 633,15м2 дугуйн болон явган зам талбайг ашиглалтад оруулсан. Мөн төв зам дагуух шороон хөрсийг эко хавтангаар хучилт хийх ажлыг эхлүүлж нийт 6370м2 талбайд хучилт хийж тоосжилтыг бууруулсан. 2023 онд нийт 5416м2 явган зам, 1850м2 дугуйн зам, 2500м2 эко хавтан тавих ажлууд хийгдэж нийт 612,613,556 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 129 | | 3. Замын хөдөлгөөн зохион байгуулах хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио хийх | 2021 - 2023 | | 16, 2000, 4 | 2021 онд Замын сангийн 21,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хурд сааруулагч” нийт 16 ширхэг, 50сая төгрөгийн хөрөнгөөр 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээ, 90 сая төгрөгийн хөрөнгөөр 1800 м2 талбайд замын нөхөөс, 2022 онд 1800м2 явган хүний зам, 1,2км хатуу хучилттай замд хучилт, 900м хатуу хучилттай авто замын шинэчлэл, шинээр 750м хатуу хучилттай авто зам, 55 машины зогсоол, сургууль орчмын бүсийн 2ш хурд сааруулагч, гэрлэн дохио хийсэн. 2023 онд 14ш хурд сааруулагч, 28 байршилд хурд сааруулагч болон явган хүний гарцын хэвтээ тэмдэг тэмдэглэгээг сэргээсэн, мөн 5-р сургууль орчмын бүсийг бүрэн харах 360 камер нэг ширхгийг тус тус суурилуулсан. | 100% |
| 130 | 3.8.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор томоохон голуудад төмөр бетонон гүүр барина. | 1. Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих | 2021 - 2024 | | 3 | 2021 онд Галуут сумын Мандалын голын 62 у/м төмөр бетон гүүрний ажлыг “ Эвт уул” ХХК , Галуут сумын Өлзийт голын төмөр бетон гүүрийн ажлыг “Их богд зам “ ХХК тус тус гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар Богд сумын Түйн гол дээгүүр төмөр бетон гүүр барих ажлын зураг төсвийг шинэчлэн боловсруулж 2024 оны улсын төсөвт тусгуулсан болно. | 70% |
| 131 | 3.8.4. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ. | 1. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх | 2021 - 2024 | | 2 | Баянхонгор аймгийн Нисэх буудлын Аэродромын зорчих хэсэг нь 21800м2 талбайд нөхөөс хийх шаардлагатай байгаагаас нислэг үйлдэх боломжгүй иргэний нисэхийн ерөнхий газрын дүгнэлт гарсан. Иргэний нисэхийн ерөнхий газраас Баянхонгор аймгийн Нисэх буудлын аэродромын зорчих хэсгийн 21800м2 талбайг засварлах ажил дээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендэрийг 3 удаа зарласан болович одоогоор гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна. Дээрхи шалтгааны улмаас Баянхонгор аймагт нислэг үйлдэх боломжгүй байгаа тул тухайн арга хэмжээ хэрэгжих боломжгүй. | 0% |
| 132 | 3.9.1. Төвлөрсөн хот сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр | 1. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станц | 2021 - 2024 | | 50 | БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж дулаан хангамжийн | барьж, ашиглалтад оруулах | | | | Инженеринг" ХХК, туслан гүйцэтгэгчээр "МЭЗ" ХХК гэрээ байгуулж ажлыг 2022 онд эхлүүлсэн. Энэ онд дулааны станцын барилгын үндсэн хийцлэл, нүүрс буулгах талбайн суурийн ажлууд тус тус хийгдэж дууссан. Ажлын явц 50%-тай үргэлжилж байна. Тус ажил нь 2024 оны 09 дүгээр сард ашиглалтад орно. | |
| 133 | чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг сайжруулна. | 2. Баянхонгор аймгийн төвийн 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээг шинэчлэх | 2023 - 2024 | | 50 | Баянхонгор аймгийн 2 дугаар хэлхээний гадна цахилгаан хангамжийн ажлыг 2024 оны улсын төсөвт тусгуулан батлуулсан. Тус ажил 2024 оны 01 дүгээр сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлана. | 30% |
| 134 | | 3. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2021 - 2023 | | 100 | Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Гал хонгор" ХХК шалгарч гэрээ байгуулан ажлыг 2022 онд эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд гадна дулааны шугам нийт 1258 м, ариутгах татуургын шугам 1320 м хийгдээд байна. Тус ажил 2024 оны 07 дугаар сард ашиглалтад орно. | 100% |
| 135 | | 4. Залуус хороололд инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2022 - 2024 | | 30 | Залуус амины орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг)-ийн ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг "Б софт" ХХК 2022 онд ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Залуус хороололд дулаан цэвэр, бохир усны шугам ажлууд 2024 он хийгдэж ашиглалтад орно. | 100% |
| 136 | 3.9.2. Зарим сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Сумын төвийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх | 2021 - 2023 | Улсын төсөв | 2 | Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК хийж гүйцэтгэн 2023 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. Тус ажлын хүрээнд 60-70 м3 хүчин чадалтай "Эколос"-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Цэвэрлэх байгууламж ажилуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус тус хийгдсэн. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Алегротовер констракшин” ХХК-тай гэрээ байгуулж төслийн хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугмын ажил, мөн 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12 нойлын өрөө/ ажлууд хийгдэнэ. Тус ажил 2024 оны 3 дугаар улиралд ашиглалтад орно. Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн гүйцэтгэгчээр “Рино инженеринг” ХХК гэрээ байгуулан ажлыг энэ онд эхлүүлсэн. Тус ажил нь 2024 оны 04 дүгээр улиралд ашиглалтад орно. | |
| 137 | | 2. Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх | 2021 - 2024 | Улсын төсөв | 1 | Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болгох ажлын хүрээнд Эрдэнэцогт сум, Галуут сумд цэвэрлэх байгууламж суурилуулах ажил төлөвлөгдсөн. Үүнээс Эрдэнэцогт сум “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажлын хүрээнд 60-70 м3 хүчин чадалтай "Эколос" цэвэрлэх байгууламжийг суурилуулсан. Галуут сумын "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн гүйцэтгэгчээр "Алегротовер констракшн" ХХК шалгаран түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Энэ онд авто зам, дугуйн зам, явган хүний зам, дулааны шугамын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2024 онд цэвэрлэх байгууламжийг суурилуулна. Тус ажлын хүрээнд захиалагчийн техникийн хяналтыг 13 удаа хийж, үүрэг, даалгавар өгч ажилласан. | 100% |
| 138 | 3.9.3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 1. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Улсын төсөв | 30 | Ус хангамжийн эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр "Баянзаг Дриллинг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсийн 9000 метр HDPE маркийн хоолойн угсралтын ажил, 500м3 усан сангийн байгуулалтын барилгын болон шугам сүлжээ, тоноглолын угсралт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүсийн шугам хоолой тоног төхөөрөмжийг "Базардарь" ХХК нийлүүлж, шугам хоолойн угсралтын ажлыг "Чандмань-Баянхонгор" ХК гүйцэтгэн тус тус ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсэд 128м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулж 640 хүүхдийн сургуулийн 100 айлын 2 нийтийн орон сууцны барилга байгууламжийг тус тус холбосон. | |
| 139 | 3.9.4. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1. Баянхонгор сумын үерийн далан суваг, борооны болон хөрсний зайлуулах хоолой хийх | 2021 - 2024 | | 30 | Баянхонгор хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Тус ажил нь 2024 оны улсын төсөвт тусгагдаагүй болно. | 100% |
| 140 | 3.9.5. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөж, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | 1. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх | 2021 - 2024 | Аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалтаар | 1 | Номгон 1-р багийн 10-р байр, Рашаант 10-р багийн 1-р байрууд дахин төлөвлөлтөд орж нийт 150 гаруй айлын орон сууж ашиглалтад орсон. Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлж, 7 давхар 4 блок орон сууцны хотхоны барилга угсралтын гүйцэтгэгчээр "Хаш гоёо" ХХК ажиллаж 1-р ээлжийн 2 блок 98 айлын орон сууцны барилгыг 2023 оны 8 сард ашиглалтад оруулсан бөгөөд 2-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгын гүйцэтгэл 95%-тай байна.Тайлант онд нийт 4 байрыг ашиглалтад оруулаад байна. | 100% |
| 141 | 3.9.6. Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана. | 2. Хонгор-1000 орон сууцны хороолол байгуулах | 2022 - 2024 | | 3 | Хонгор-1000 орон сууцны хороололд 17 байршил дээр нийтийн орон сууцны зориулалтаар газар олголт хийгдсэн. Мөн Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор 1000 орон сууцны хорооллын талбайг өргөжүүлэн Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулсан тухай АИТХурлын 2022 _8/12 тоот тогтоолоор нийтийн орон сууцны газруудыг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт эзэмшүүлсэн бөгөөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022,2023 онуудад төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна. | |
| 142 | | 3. Хувийн хөрөнгө оруулалтаар аймаг болон сумдад нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 250 | Хувийн хөрөнгө оруулалтаар энэ онд 680 айлын 15 нийтийн орон сууцны барилга ашиглалтад оруулаад байна. | 100% |
| 143 | 3.9.7. Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлж, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станцыг шинэчилнэ. | 1. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх | 2022 - 2024 | | 60 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 110/35/10кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "ДМТМ" ХХК хийж гүйцэтгэж байна. тус ажлын хүрээнд 110кВ-ын ХХБ-ийн барилгын ажил, 16 МВТ-ын трансформатор секц 1-ийг 10 кВ руу шилжүүлж ажил, 5 МВАр SVG-1 тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил, 10кВ-ын тулгуур солих, трансформаторын хайрга солих, 10кВ-ын гаргалгааны кабелийн ажил, 110 кВ-ын Т-1 трансформаторын саармаг цэг дээр NGP-110 маркийн саармаг цэгийн салгуур шинээр суурилуулах, 110 кВ-ын Т-1 талын LCWB6, 50/5 гүйдлийн трансформаторыг LB7-110/W3, 150/5 гүйдлийн трансформатороор солих ажлууд тус тус хийгдээд байна. Тус ажил нь 2024 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулна. | 100% |
| 144 | 3.9.8. Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө. | 1. Шаардлагатай сум, багийн үүрэн холбооны 2G, 3G, 4G, 5G сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэх | 2022 - 2023 | | 8 | Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мянган өндөр цамхаг" ХХК Өлзийт, Эрдэнэцогт, Гурванбулаг, Баянлиг, Хүрээмарал, Баянцагаан сумдын алслагдсан багуудад үүрэн холбооны сүлжээний цамхаг барьж 2023 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. | 100% |
| 145 | 3.9.9. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна. | 1. Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх | 2022 - 2024 | | 4 , 4 | 2019 оноос хэрэгжүүлж буй "Ухаалаг цамхаг" төслийг нийт 270 сая төгрөгөөр Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн нутаг дэвсгэрт утасгүй сүлжээний орчин бий болгохоор ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хүлээлгэж өгөөгүй байгаа бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлсэн. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
| 146 | 4.1.1. "Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 44 | Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор аймгийн хэмжээний хүний нөөцийн нэгдсэн суурь судалгааг гаргах ажлын хэсгийг томилж, аймгийн хэмжээний 181 төрийн байгууллагын 5079 төрийн албан хаагч судалгаанд хамруулаад байна. Төрийн албаны сонгон шалгаруулалт, ажлын байрны сул орон тооны судалгаа, мэдээлэлд үндэслэн 2023-2026 онд хэрэгжүүлэх "Төрийн мэргэшсэн албан хаагч" хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 181 төрийн байгууллагын 82 нь буюу 45,3 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна | 100% |
| 147 | 4.2.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна. | 1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг чангатгах | 2021 - 2024 | | 120 | Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, Төрийн албаны суурь өгөгдлийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх, Төрийн албан хаагчдын албаны цахим хэрэглээг сайжруулах, чадавхжуулах, бүтээлч санал санаачилгыг дэмжих зорилгоор аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дунд аяныг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газартай хамтран зохион байгууллаа. Аяны хүрээнд: Нийт 35 байгууллага тайлангаа ирүүлж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангуулан ажилласан. Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм журмын шинэчлэлийн дагуу байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлыг нийт 31 байгууллагын 400 гаруй албан хаагчид хамрагдаж, байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ажлыг дотоод журамдаа тусган хэрэгжүүлсэн байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх аяныг байгууллагууд зохион байгуулж журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн төрийн албаны "ХНУМТ" цахим системд мэдээллийг үнэн зөв оруулах, мэдээллийн шинэчлэх асуудлыг сум байгууллагын дарга, удирдлагуудад чиглэл хүргүүлж, холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулаа. | |
| 148 | 4.3.1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох. | 1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах | 2021 - 2024 | | 90 | Аймгийн хэмжээнд Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын мэргэшүүлэх судалгаанд 40 агентлаг, байгууллагын 265 албан хаагчийн хамруулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Энэхүү судалгаанаас харахад төрийн байгууллагад ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тэр тусмаа сумд ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтэн байхгүй нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа сумдад доголдож байна. Улсын хэмжээнд Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академиас зохион байгуулж байгаа Төрийн албан хаагчдын цахим ур чадварын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд 1124 албан хаагчийг идэвхтэй хамруулав. тус судалгааны нэгдсэн дүнг И-Монгол академи танилцуулна. Судалгааны линк: https://forms.office.com/r/TrveuCXa3d | 100% |
| 149 | | 2. Мэдээллийн технологийн | 2022 - 2024 | | 50 | Аймгийн төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудыг 2020 оноос хойш "ДИЖИТАЛ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах | | | | БАЯНХОНГОР" арга хэмжээний хүрээнд тогтмол чадавхжуулан ажиллаж байна. 2023 онд аймаг сумдын 80 гаруй байгууллагын IT нарт , SUPER ADMIN (http://empasoft.mn:5000/trainingView/2/content), Цахим хөгжлийн багц хуулиуд, Цахим жишиг аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх аргазүйн зөвлөгөө, Цахим ур чадвар олгох сургалт (I,II,III багц) сургалтуудад бүрэн хамруулж нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажилласан. | |
| 150 | 4.3.2. E-Mongolia хөтөлбөрийн хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”–ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна. | 1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 124 2000 | Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор "ХУРДАН" цэгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт, Баруун бүсийн худалдааны төвд, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн байранд тус бүр 3 цэг шинээр байгуулан ажиллаж 2023 оны 12 сарын байдлаар 16.000 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. | 100% |
| 151 | 4.3.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ. | 1. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | 2022 - 2024 | | 40 | “Цахим аймаг” бодлогын зөвлөмж, “DIGITAL BAYANKHONGOR” арга хэмжээ ИМОНГОЛ УТҮГ-ын иргэдэд чиглэсэн сургалтуудад иргэд болон төрийн албан хаагчдыг хамруулсан тус арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 700 гаруй иргэнийг хамруулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт өссөн дүнгээр бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд 3500 гаруй иргэдэд хүрч, олон талт арга хэмжээг зохион байгуулж ажиллаж гүйцэтгэл 35 хувьтай байна. 2024 онд "Digital first" арга хэмжээг зохион байгуулна. | 90% |
| 152 | | 2. Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, | 2022 - 2024 | 20.0 орон нутгийн төсөв | 90 50 | Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх irgen.bayanhongor.gov.mn цахим системийг аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах | | | | хэмжээнд нэвтрүүлж 2023 оны жилийн эцсийн байдлаар 1293 өргөдөл, гомдол санал, хүсэлт ирж шийдвэрлэх, холбогдох албан тушаалтад хүргэгдсэн байна. Баянхонгор аймаг нь 2021 оноос тусгай зөвшөөрөл хүссэн иргэн ААН-ын хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор 2023 оны 11 сард И-МОНГОЛ УТҮГ тай хамтран ажиллаж процесс анализ хийн үйлчилгээний судалгааг хийсэн. 2024 онд 145 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээс 24 төрлийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох үйлчилгээ байна. | |
| 153 | | 3. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийх | 2022 - 2024 | | 70 | Төрийн байгууллагуудад цахим хяналт, мэдээллийн нэгдсэн ДАШБОАРД-ыг "Цахим аймаг" бодлогын хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хөгжүүлж аймгийн удирдлагуудыг өдөр тутмын нэн шаардлагатай мэдээллээр хангана. 2022-2023 онд мэдээллийн нэгсэн сангийн зохион байгуулалт болон ажлын даалгавруудыг боловсруулж дууссан. Иргэдийн санал, гомдол илгээх систем irgen.bayanhongor.gov.mn цахим системийг 20.0 сая төгрөгийн төсөвтэй Анарсистемс ххк-тай гэрээ байгуулан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж дууссан. | 100% |
| 154 | 4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Виртуал аялал хийх боломжтой "VR-Bayankhongor" төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх | 2022 - 2024 | Хандив тусламж 250,0 сая | 600 | 2024 онд аялал жуулчлалын ""Баянхонгор аяллын хөтөч"" гар утасны апп-ыг нэвтрүүлэх бөгөөд 2023 онд зураг, ажлын даалгавар боловсруулагдаж дууссан байна. Мөн Баянхонгор сумд ""Виртуал Баянхонгор"" төвийг байгуулж тус төв нь VR технологи ашиглаж Баянхонгор аймгийн үзэсгэлэнт 7 газраар аялал хийх зориулалт бүхий төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Баянхонгор аймгийн Аймгийн ОНӨГ-с энэхүү төвийг хувийн хэвшилд төсөл сонгон шалгаруулах замаар хувьчлах үйл ажиллагаа явуулж ""Айети Юнипикэшн"" ХХК-ний төсөл шалгарч гэрээ байгуулсан. ""Баянхонгор аялал жуулчлал"" facebook хуудсаар аймгийн хэмжээний аялал жуулчлалын мэдээллийг нээлттэй мэдээлж байна. | 30% |
| 155 | | 2. 20 сумын төвийн | 2021 - | | 100 | 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 20.0 сая төгрөг | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллыг заасан 360, VR, зураг, дүрсний танилцуулгыг хөгжүүлж Google street-д байршуулах | 2023 | | | тусгасан боловч төсөв хэт бага байсан тул энэхүү ажлыг гүйцэтгэх ААН олдоогүй ба тус системийн техникийн нөхцөл, ажлын даалгавар бүрэн боловсруулагдаж дууссан нь нийт хөгжүүлэлтийн 25 хувь хийгдсэн байна. Тиймээс 2024 онд хэрэгжих "Цахим жишиг аймаг" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээний нэгдсэн АПП хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 156 | 4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 8 сая төгрөг | 2 72 48 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/48 дугаар захирамжаар 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөн биелэлтийг 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. Авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд аймгийн хэмжээнд 10 төрлийн сургалт бэлтгэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж 126 сум, байгууллагуудын 17.000 иргэд, төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл хийж, Авлигын эсрэг хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжоор 25 төрлийн постер, 9 төрлийн видео, 15 төрлийн гарын авлагыг хийж нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулан ажилласан.Аймгийн хэмжээнд авлигын эсрэг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлуудыг үе шаттай зохион байгуулсны үр дүнд аймгийн цахим хуудасны үнэлгээ 2022 онд 67,01 хувьтай байсан бол 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 89,01 хувь болж 22 хувиар өссөн. Авлигын гэмт хэрэг 2022 онд 15 бүртгэгдэж байсан бол энэ оны 11 сарын байдлаар 14 бүртгэгдэж өмнөх оноос 1 нэгжээр буурсан зэрэг эерэг үзүүлэлттэй дүгнэгдэж байна | 100% |
| 157 | 4.4.1. Тодорхой төрлийн гэмт | 1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 3.3 | 124 , 1721 | "Зөв амьдрал" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна. | хэрэг зөрчлийн тоог бууруулах | | сая/төг- | | А/33 дугаар захирамжаар батлуулан,биелэлт 100 хувьтай байна. “Жаргалтай амьдрал төв”-ийн үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 100.0 сая/төг-ийг шийдвэрлэж, архинд донтох өвчтэй 83 иргэн хэвтэн эмчлүүлснээс 59 иргэн буюу 72 хувь нь эдгэрэлтэй байна Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох журмаар давхардсан тоогоор 810 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт цахимаар болон танхимын сургалтыг зохион байгуулж, 430 аж ахуйн нэгжид 4 төрлийн 1720 гарын авлагыг түгээж ажиллалаа. Шүүхийн шийтгэврээр баривчлагдсан 551, эрүүлжүүлэгдсэн 86, албадан саатуулагдсан 334 этгээдэд 174 удаагийн 502 цагийн сургалтыг давхардсан тоогоор 3021 этгээд, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 145 удаагийн 294 цагийн сургалтыг 10346 иргэн, төрийн албан хаагчдад тус тус зохион байгууллаа. “Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардах нь хуулиар хориглосон үйлдэл "би ч нэгдэнэ, та ч бас нэгд" challenge-ийг өрнүүлж, 30 байгууллагын 700 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Тус хуулийн 27.2, 28.2 дахь заалтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл бүхий масс мессежийг юнителийн 16110 хэрэглэгчдэд илгээсэн. Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн хариуцлагатай үйлчилгээний ажилтныг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, 20 аж ахуйн нэгжийн 35 ажилтныг хамруулаад байна.Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 11 сарын байдлаар 107 бүртгэгдэж 4 нэгжээр, зөрчил 1512 бүртгэгдэж 267 нэгжээр тус тус буурсан байна. | |
| 158 | | 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж | 2021 - 2024 | | 41 , 153 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/34 дүгээр захирамжаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах | | | | батлуулан, 100 хувьтай биелсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 5 нэгдсэн арга хэмжээ, 3 хэсэгчилсэн арга хэмжээ, 2 зөвлөгөөн, 137 удаагийн сургалтыг 8950 иргэнийг хамруулан зохион байгуулж ажиллалаа. Энэ оны 11 сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 27 бүртгэгдэж 12 нэгжээр буюу 30.7 хувиар, зөрчил 206 бүртгэгдэж 44 нэгжээр буюу 17.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. | |
| 159 | | 3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | Орон нутгий төсөв 5,0 сая төгрөг | 21 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/145 дугаар захирамжаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөлийн төлөвлөгөөг батлуулж 100 хувьтай хэрэгжилтийг хангаж ажиллав. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Замын хөдөлгөөнд мотоцикл жолоодон оролцогч нарт 2 төрлийн 480 ширхэг анхааруулга, сэрэмжлүүлэг тарааж 3 удаагийн хэсэгчилсэн хяналт шалгалтыг зохион байгуулан гудамж замын хяналт шалгалтаар 23 зөрчилд 250,000 төгрөгийн шийтгэл оногдуулж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ мотоцикл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 5 зөрчил, эрхгүй үедээ мотоцикл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 1 зөрчил тус тус илрүүлж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг өмнөх мөн үетэй харьцуулахад 11 сарын байдлаар ижил түвшинд байна. | 90% |
| 160 | | 4. Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 10, сая төгрөг | 63 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн санаачилга, малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Шилдэг Малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, ИТХ-ын даргын 2023 оны 1б/113 дугаар албан бичгээр сумын ГХУСАЗСЗ, Засаг даргад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Шилдэг малчдын бүлгээр Бууцагаан сум тэргүүн байр, Эрдэнэцогт сум дэд байр, Жаргалант сум гутгаар байранд тус тус эзэлж, мөнгөн шагналаар шагнасан. Мал хулгайлах гэмт хэрэг 11 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвшинд байна. | |
| 161 | | 5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 10,0 сая төгрөг | 58 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ОНТ-өөс 10.0 сая/төг-ийг шийдвэрлэж, нийтийн эзэмшлийн гудамж талбайд 7 ширхэг шинэ камер байршуулж, 500 метр шилэн кабель татаж, 5 цэгийн камерын гэмтлийг засварласан. Гэмт хэргийн илрүүлэлт 11 сарын байдлаар 45.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 хувиар өссөн | 70% |
| 162 | | 7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 10.0 сая төг | 50 | Баянхонгор сумын ГХУСАЗСЗ-ийн төсвөөс 190.0 сая/төг-ийг шийдвэрлүүлж, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 34 цэгт 53 ширхэг хяналтын камерыг суурилуулж, “Ногоон бүс” төслийн хүрээнд 4 цэгт автомашины дугаар танигч, машин, мотоцикл тоологч систем бүхий 4 ширхэг хяналтын камерыг байршуулан, 500 метр шилэн кабель татаж, 5 цэгийн камерын гэмтлийг засварласан байна. -Жинст сумд шинээр 4 цэгт 9, Галуут сумд шинээр 6 цэгт 13, Баацагаан сумд 4 цэгт 10, Жаргалант сумд 4 цэгт 12, Бөмбөгөр сумд шинээр 6 цэгт 12 ширхэг хяналтын камерын суурилуулалт хийгдэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шалган нэвтрүүлэх байрны камержуулалтын ажилд ОНТ-өөс 10.0 сая/төг-ийг шийдвэрлэж, “Шижир зоос индранил” ХХК-тай гэрээ байгуулж, Цагдан хорих байрны шалган болон конторт 12 ширхэг камер, байгууллагын гадна хэсэгт 2 ширхэг камер нийт 14 ширхэг телекамер суурилуулж, 5 ширхэг камерыг нөөцөлсөн байна.Гэмт хэргийн илрүүлэлт 11 сарын байдлаар 45.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 хувиар өссөн. | 100% |
| 163 | 4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, | 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 10.0 сая/төг | 1600 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар батлан, 100 хувьтай хэрэгжсэн байна. Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 55 байгууллагын 18550 гаруй иргэд, төрийн албан хаагч, сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ. | нэмэгдүүлэх | | | | танхимын сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажилласан. 20 хууль тогтоомжоор 70 гаруй төрлийн постер, 43 төрлийн гарын авлага бэлтгэж, 800000 гарын авлагыг иргэдэд түгээж, орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, мэдээллийн самбараар тогтмол сурталчлан, иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа. Мөн шинэчлэн найруулга хийгдэх 6 хууль, 4 журам, аймгийн ИТХ-ын 1 тогтоол, 1 захирамжийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг 15 удаа зохион тушаалтанд хүргүүлэн ажилласан. байгуулж, холбогдох байгууллага, албан -Аймгийн хэмжээнд эрх зүйн хөтчөөр бэлтгэгдэн идэвхтэй ажиллаж байгаа 167 албан хаагчдаас 55 эрх зүйн хөтчийг цахим болон тахимын хэлбэрээр давтан сургах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 16,17-ний өдрүүдэд зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажилласан.Хүрсэн түвшин иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшилсэн | |
| 164 | 4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна. | 1. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээнд тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. | 2021 - 2024 | Орон нутгийн төсөв 8.0 сая/төг | 60 | Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээний төвд соёлч боловсон үйлчилгээг нэвтрүүлэх, үйл ажиллагааг тоон системд нэвтрүүлж хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.6 дахь заалтад тусган батлуулж, хэрэгжилтийг хангах зорилгоор Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/176 дугаар захирамжаар хөрөнгийн 8.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлснээр Шижир зоос индранил ХХК-тай гэрээ байгуулан дуудалт, хяналтын системийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний А/108 дугаар тушаалаар хүлээн авч үйлчилгээнд ашиглаж эхэллээ. Архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээний төвд соёлч боловсон үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. | 30% |
| 165 | | 2. Төрийн болон байгууллагын | 2021 - 2023 | | 70 , 0 | Тус онд дараах ажлыг зохион байгууллаа. 1. Төрийн архивын цахим санд хадгалагдаж байгаа 2.42 ТВ багтаамж | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах. | | | | бүхий 815,807 баримтыг нөөц серверт шилжүүлэх ажлыг Архивын ерөнхий газартай хамтран зохион байгуулж хадгалалт хамгаалалтыг сайжруулаа. 2.Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 1070, , бүрдүүлэлтээр хүлээн авсан сан үүсгэгч 163 байгууллагын үндсэн 2020, нэмэлт 2007-2019 онуудын 14574 хадгаламжийн нэгжийн 231307 хуудас цаасан баримтыг хамгаалах хайрцагт бүрэн шилжүүлж хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллалаа. 3.Төрийн архивын цахим санд хадгалагдаж байгаа 2.42 TB багтаамж бүхий 815,807 баримтыг нөөц серверт шилжүүлэх ажлыг Архивын ерөнхий газартай хамтран зохион байгуулж хадгалалт хамгаалалтыг сайжруулаа | |
| 166 | | 3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх. | 2021 - 2024 | | 86 | “Цахим архив–Баянхонгор” дэд хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/50 дугаар захирамжаар батлаж ажиллалаа. Үүнд: 1.Төрийн архивын ажилтнууд “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын цахим сангийн ажилтнууд сан хөмрөгт хадгалагдаж байгаа 47 хөмрөгийн 1704 хадгаламжийн нэгжийн 93115 хуудас баримтыг цахим системд бүрэн шилжүүлж, 408607 өгөгдөл оруулж баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж, лавлагаа мэдээллийг онлайнаар үзэх боломжийг бүрдүүллээ.11/30 2.Байгууллагуудын архивын ажилтнууд Төрийн болон төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын сан үүсгэгч 163 байгууллагын үндсэн 2020, нэмэлт 2007-2019 онуудын 14574 хадгаламжийн нэгжийн 231307 хуудас цаасан баримтыг 04 дүгээр сарын 03-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд хүлээн авч, цахим санд шилжүүлж ажилласнаар баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж, онлайнаар хайлт хийх боломжийг бүрдүүллээ. Энэ үйл ажиллагаанд нийт 290 албан хаагч, ажилтнууд ажиллалаа. | 70% |
| 167 | | 4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг | 2021 - 2024 | | 0,22 | Төрийн архивын ажилтнууд нь Архивын үнэ цэнтэй, насжилт өндөртэй, муудаж урагдсан цаастай сонгогдсон 56 хадгаламжийн нэгж баримтад цахим, нөөц хувь бий болгох, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэлбэн засах. | | | | ашиглалтаас чөлөөлөх, мөн 2800 хуудас баримтыг сэлбэн засах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж насжилтыг уртасгах арга хэмжээ зохион байгуулсан. | |
| 5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 168 | 5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ. | 2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих | 2021 - 2024 | Аж ахуйн нэгж, хувийн хөрөнгө, Улсын болон орон нутгийн төсөв - 892.3 | 50000,50 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10731 иргэн, 1253 айл өрх 17 төрлийн 14373 ширхэг мод, 333 аж ахуйн нэгж, байгууллага 15949 ширхэг мод, жимсний палантац 3 га талбайд байгуулж 2100 ширхэг жимсний суулгац тарьж, Цэцэрлэгт хүрээлэнд 12,8 га талбайд 12170 ширхэг мод, нийтийн эзэмшлийн талбайд 18,4 га талбайд 23233 ширхэг мод, хамгаалалтын ойн зурвас 46,3 га талбайд 39666 ширхэг мод, ойжуулалт 22,7 га талбайд 7195 ширхэг мод, Мод үржүүлгийн газрууд 187623 ширхэг тарьц суулгацыг мөчир болон үрээр тарьж ургуулж байна. Аймгийн хэмжээнд 2023 онд суулгацаар 114,686 ширхэг, үрээр болон мөчрөөр 187,623 ширхэг нийт 302,309 ширхэг модыг тарьж, бойжуулж байна. Нийт модны ургалт 76%-тай байна. | 100% |
| 169 | | 3. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 20 | Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 2022 онд ШУТИС-ийн харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн боловсруулсан. Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын захиалгаар "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ нь 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 08 дугаар сарын 06-ны хооронд Ойн санд хөнөөлт шавжийн голомт тархалтыг тогтоох судалгааг 7 сумын нутаг дэвсгэрийн 230200 га талбайд хийилгэхэд 29700 га талбайд тархалттай, 6544 га талбайд голомт илэрсэн бөгөөд 2024 оноос эхлэн 7000 га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн Заган ойн сэргэн ургалтыг дэмжих ажлын хүрээнд Баян-Өндөр, Шинэжинст, Баацагаан сумдын нутаг дэвсгэрт 2020 оноос хойш 50 га талбай хашиж хамгаалсан, ирэх онд тус төсөлтэй хамтран заг бүхий 1000 га талбайг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 170 | | 4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 30 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 08-ны өдрийн хооронд "Баян бороо-1,2" дугаар экспедиц нийт 3 удаа зохион байгуулсан. Эхний цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаагаар 8 сумын нутагт 0.0-4.0 мм хүртэлх цас, хоёр дахь удаа 12 сумын нутагт 0.0-3.0 мм цас орсон бол гурав дахь удаа 9 сумын нутгаар олон жилийн дунджаас 4.1-25.3 миллиметрээр их хур тунадас орсон. Энэ цаг агаарт нөлөөлөх ажлын үр дүнд 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 80-90 хувьд хамруулж хур тунадас нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийн тооцвол 161,7 сая төгрөгт хүрсэн. | 100% |
| 171 | 5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | 1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах | 2021 - 2024 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 50.0, Төсөл – 34.6 | 3 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Бөмбөгөр сум 2 булаг, Галуут сум 2 булгийн эхийг хашиж хамгаалсан. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд зэрлэг ан амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Шуудуугийн булаг, Баянцагаан сумын Баянбулаг булаг, Шинэжинст сумын Хаяа булгийн эхийг тус тус хашиж хамгаалсан. Ингэснээр энэ онд нийт 7 булгийн эхийг хашиж хамгаалсан. Жаргалант сумын 1 дүгээр багийн нутаг Будын эх гэх газарт янгир ямааны байршил бүхий бүсэд уулын гуу жалгыг ашиглан зэрлэг амьтдыг усаар хангах зорилгоор 20х15 харьцаатай хөв байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд зэрлэг ан амьтдын ус хангамжийг сайжруулах зорилгоор Баацагаан сумын Товгор багт, Шинэжинст сумын Цагаан сайр нэртэй газар хуучин цооног, Баян-Өндөр сумын Идрэн багт шинээр худаг гарган нарны өргүүртэй болгон тус тус тохижуулсан | 100% |
| 172 | | 2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион | 2021 - 2024 | | 150 | Ангийн бүс нутагтай Өлзийт, Жаргалант, Галуут, Жинст зэрэг сумууд тухайн бүс нутгийг хариуцан хамгаалах чиглэлээр байгуулагдсан нөхөрлөлүүд сумдын Байгаль орчны албатай хамтран биотехникийн арга хэмжээг хамтран тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Мөн Бууцагаан сумын “Дээд Ариусгал” нөхөрлөл шинээр байгуулагдсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | бөгөөд гэрчилгээ олгож бүртгэлжүүллээ. Тус нөхөрлөл нь уст цэг, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Бөмбөгөр, Шинэжинст, Жинст, Өлзийт, Жаргалант зэрэг сумд ангийн бүс нутаг болон хариуцан хамгаалан ажилладаг бүс нутгийн нөхөрлөлүүд нь иргэдэд тус сумдын байгаль орчны албатай хамтран сургалт мэдээллийг 280 орчим иргэн болон нөхөрлөлд мэдээлэл өгсөн. Мөн “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслөөс Шинэжинст сумын малчдын бүлгийн говийн бүсэд мод тарих ажилд 2 га талбайн усалгааны систем, хашаа хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. | |
| 173 | 5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна. | 1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах | 2021 - 2024 | | 3 | Аймгийн хэмжээнд 2023 оны 01-05 дугаар сарын хооронд зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг хэсэгчлэн зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Баянбулаг, Жаргалант, Галуут, Бууцагаан, Гурванбулаг, Заг, Жинст, Хүрээмарал, Богд, Шинэжинст, Баян-Овоо, Бөмбөгөр зэрэг нийт 15 сумын нутаг дэвсгэрийг хамруулан зэрлэг амьтдын байршил бүхий газруудад идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлж 36 удаагийн давтамжтай өвс 1423 боодол, хужир 19 тонн, хорголжин 47 шуудай байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Биотехникийн арга хэмжээ авах үед Янгир ямаа-393, Аргаль угалз-96, Буга, согоо-56 тоо толгойг нүдээр үзэж тоолсон. | 100% |
| 174 | 5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана. | 1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 70 | Орог нуур түйн голын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний II үе шатын 2023 оны жилийн эцсийн биелэлт 17 зорилт, 27 арга хэмжээний хүрээнд 105 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээс хэрэгжсэн ажил-80, хугацаа хүлээгдэж буй ажил-25, нийт 76 хувьтай хэрэгжүүлсэн байна. Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Монхидроконстракшн” ХХК-тай хамтран боловсруулж Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөл, Аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газарт батлуулахаар хүргүүлсэн. | |
| 175 | 5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Орон нутгийн хөгжлийн сан – 18,0 | 50 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталсан. Тус хөтөлбөрийг энэ онд 79,6 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог аймгийн хэмжээнд нэвтрүүлж ажилласан. Энэ онд шинээр 14 сум 94 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулсан. Баян-Өндөр, Баянцагаан, Галуут сумдад хоёрдогч түүхий эд худалдан авч, борлуулдаг иргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өлзийт сум энэ оны 06 дугаар сараас эхлэн сар бүрийн сүүлийн долоо хоногийн Бямба гарагийг дахивар худалдан авдаг өдөр болгож нийт 7000 ширхэг шил, 2,4тн дахивар хогийг цуглуулж “Хонгор дуулим” ХХК-д нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. Баянхонгор сум 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэж эхэлсэн. Уг ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн 80 орчим хувь нь хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшсэн. Энэ оны жилийн эцсийн байдлаар 2844 тн үнс, 12,84 тн хуванцар буюу нийт хог хаягдлын 14,5%-ийг ангилж ялган эдийн засгийн эргэлтэд оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн санхүүжилтээр Эко кэш буюу хуванцар худалдан авдаг автомат машиныг суурилуулсан. 2023 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2023 оны "Эрүүл цэвэр-аюулгүй орчин бүрдүүлэх тухай" 02 дугаар албан даалгаврын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбай, ил задгай, авто зам дагуу 3312 тн, аялал жуулчлалын бүс нутаг дахь уул овоо болон усны сав газарт 1456 тн, малын сэг зэм 168 тн нийт давхардсан тоогоор 26923 гаруй иргэний оролцоотойгоор 5564 га талбайн 4936 тн хог хаягдлыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэвэрлэсэн. | |
| 176 | 5.3.2. Баянхонгор сумын гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбоно. | 1. Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох | 2022 - 2024 | | 60 | Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг) ажлын зургийг иж бүрнээр нь “ДНТ” ХХК-аар 2022 онд гүйцэтгүүлсэн. Баянхонгор сумын “Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ”-ний ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад “Б-СОФТ” ХХК шалгарсан бөгөөд 2022.04.22-ны өдөр 25,328,313,851 төгрөгийн төсөвтэй 2022/64 дүгээр гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2022 онд гадна ус, дулаан хангамжийн 1620 м шугам, 2023 онд 1480 м шугам, гадна ариутгах татуурга 2022 онд 2000 м шугам, 2023 онд 4620 м шугам, халаалтын зуухны 15 м x 30 м харьцаатай барилгын суурийн цутгалтын ажил, гадна цэвэр ус 2022 онд 1500 м шугам, 2023 онд 3200 м шугам, УДДТөвийн 12 м x 9 м харьцаатай барилгын суурийн цутгалтын ажил тус тус хийгдсэн. Дээрх хийгдсэн ажлуудад захиалагчийн техникийн хяналтыг 14 удаа хийсэн. | 100% |

oOo